

Улсын бүртгэлийн дугаар  
9095578

Нууцын зэрэглэл: Б

Аравтын бүрэн  
ангилалын код

Сэдэвт ажлыг хэрэгжүүлэх  
гэрээний дугаар: ШуСс\_2018/22

## ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ ФИЗИК ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

# НАНО-СОРОНЗОНГИЙН ОНЦЛОГ, ТҮҮНИЙГ ХАВДРЫН ЭМЧИЛГЭЭНД ХЭРЭГЛЭХ БОЛОМЖ

Шинжлэх ухаан технологийн төслийн тайлан

2018 – 2021

Төслийн удирдагч: ..... Д.Сангаа, ШУ-ны доктор (ScD)

Санхүүжүүлэгч байгуулага: Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч байгуулага: Боловсрол, шинжлэх ухааны яам

Тайлан өмчлөгч: Физик, Технологийн Хүрээлэн  
Энхтайваны Өргөн чөлөө 54Б.  
Улаанбаатар 13330, Монгол улс  
Утас: 99194346,  
Э-хаяг: dsangaa@gmail.com

Улаанбаатар  
2022

**Сэдэвт ажлын гүйцэтгэгчид:**

**Сэдвийн удирдагч:**

Д.Сангаа ШУА-ийн ФТХ-ийн Функциональ материалын лабораторийн эрдэм шинжилгээний ажилтан, Академич

**Үндсэн гүйцэтгэгчид:**

Н.Жаргалан ШУА-ийн ФТХ-ийн Функциональ материалын лабораторийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Доктор

Э.Уянга ШУА-ийн ФТХ-ийн Функциональ материалын лабораторийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, Доктор

И.Хишигдэмбэрэл ШУА-ийн ФТХ-ийн Функциональ материалын лабораторийн эрдэм шинжилгээний дэд ажилтан, Докторант

Б.Хонгорзул ШУА-ийн ФТХ-ийн Функциональ материалын лабораторийн эрдэм шинжилгээний дэд ажилтан, Докторант

Б.Энхмэнд ШУА-ийн ФТХ-ийн Функциональ материалын лабораторийн эрдэм шинжилгээний дэд ажилтан, Магистр

**Гэрээт ажилтан:**

Э.Дамдинсүрэн МУИС, ШУС, Байгалийн ухааны сургууль, Доктор

Д.Одхүү БНСУ-ын Инчеоны улсын их сургууль, Доктор, Проф

Э.Баянжаргал ШУА-ийн ФТХ-ийн Багажит анализын лаборатори, Инженер

Ч.Энхболд ХСҮТ-ийн эмч, Анагаах ухааны доктор

**Хамтран ажилласан гадаад, дотоодын их дээд сургууль, лабораториуд:**

ШУА –ийн Биологийн Хүрээлэн;

ОХУ –ын Дубнагийн Цөмийн Шинжилгээний Нэгдсэн Институт;

ОХУ –ын Москвагийн Улсын Их Сургууль;

Япон улсын Нийхамагийн технологийн институт

## РЕФЕРАТ

Шинжлэх ухаан, технологийн сантай байгуулсан SST\_2018/22 тоот гэрээний дагуу “Нано-соронзонгийн онцлог, түүнийг хавдрын эмчилгээнд хэрэглэх боломж” суурь судалгааны төсөл ШУА-ийн Физик, технологийн хүрээлэн дээр 2018-2020 онд хэрэгжсэн. Төслийн зорилго нь холимог металл агуулсан соронзон нано материалын дотоод тогтцын зүй тогтол, соронзон шинж чанарыг квант механикийн онолоор болон атомын бүтцийн рентген дифракц, нил улаан туяаны спектрометрийн аргаар судлах явдал юм.

Соронзон шинж чанартай нано материалыг анагаах ухаанд хавдрын халуун эмчилгээ, соронзон резонанс зураг (MRI) оношлогоо, эмийн эмчилгээ, Дезоксирибонуклейны хүчил (ДНХ) болон эсийн нарийвчилсан ялгах шинжилгээ зэрэг чиглэлүүдээр ашиглаж байна. Тэр дундаа ферритүүд ( $MFe_2O_4$ ,  $M = Mn, Ni, Co, Cu, Mg, Zn, Fe$  г.м.) нь хольц элемент ашигласнаар соронзон шинж чанарыг нь өөрчилж, дулаан ялгаруулах чадамжийг удирдаж болдог учир өргөнөөр судлагдаж байна [1, 2].

Төслийн хүрээнд хэрэгжүүлсэн судалгааны ажлын хүрээнд бид дараах үр дүнгүүдийг гарган авлаа. Үүнд:

- Энгийн болон урвуу шпинел бүтцийн тохиолдолд феррит нэгдлийн электрон бүтэц, соронзон шинж чанарын онолын судалгааг гүйцэтгэснээр магни болон төмрийн атомуудын байрлал тетраэдр болон октаэдр байрлалд хэрхэн суухаас түүний соронзон шинж чанар хүчтэй хамаарч байгааг тооцоолон гаргав.
- Төмөр агуулсан феррит нэгдлүүдийг гарган авах химийн синтезийн горимыг тогтоох ажлыг гүйцэтгэв. Золь-гелийн аргаар гарган авсан  $MgFe_2O_4$  дээж нь куб шпинел бүтэцтэй, ямар нэгэн хольц байхгүй цэвэршилт өндөртэй, кристаллитын хэмжээ тохиромжтой (~50нм), дулаан дулаан ялгаруулах чадамж өндөр ( $42^\circ$ ) байв.
- Цэвэр магнийн ферритийн кристалл бүтцийн А болон В дэд торуудад орших катионуудыг соронзон болон соронзон бус шинж чанартай элементүүдээр хольцлох замаар катионы түгэлт, бүтэц, шинж чанарыг удирдах судалгааг явуулав.

- Дээрх судалгааны ажлуудад үндэслэн хамгийн өндөн дулаан ялгаруулах чадамж бүхий феррит нано материалыг хавдрын эс дээрх туршилтыг гүйцэтгэв. Бид судалгаандаа хүний умайн хүзүүний хавдрын эсийг сонгон авч  $Mg_{0.8}Ni_{0.2}Fe_2O_4$  соронзон шинж чанар бүхий нано ферритийг ашиглан эсийн амьдрах чадварын үнэлгээг хийлээ.
- Өөрсдийн угсарсан соронзон орон үүсгэгч төхөөрөмжөөр халалт үүсгэж эсийн ургалтыг дарангуйлж байгаа эсэхийг судлан үзэхэд бидний гарган авсан феррит нано бөөм нь HeLa эсийн ургалтыг 16.8% -иар дарангуйлж байв.

Төслийн үр дүнгээр эрдэм шинжилгээний эрдэм шинжилгээний өгүүлэл – 15, мэргэжлийн ном – 1, танин мэдэхүйн ном – 1 хэвлүүлж, эрдэм шинжилгээний илтгэл 9-ийг хэлэлцүүлснээс 4-ийг олон улсын хуралд илтгэсэн байна. Мөн 1 судлаач “Магни болон Зэсийн феррит нэгдлүүдийн соронзон шинж чанарын онолын судалгаа” сэдвээр физикийн магистрын зэрэг хамгааллаа.

**Түлхүүр үг:** Феррит; шпинель бүтэц; хольц; кристалл болон молекул бүтэц; стехиометрийн харьцаа; DFT тооцоолол; хавдрын эс

## АГУУЛГА


<b>НЭГ. СОРОНЗОН НАНО МАТЕРИАЛЫН ОНЦЛОГ</b> .....	7
1.1. Шпинел феррит нэгдлүүд .....	7
1.2. Феррит нано материалын дулаан ялгаруулах үзэгдэл .....	12
1.3. Дулаан ялгарах үзэгдлийг судлах арга зүй.....	16
<b>ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ</b> .....	18
2.1. Феррит нано материал гарган авах аргууд.....	18
2.2. Бүтцийн судалгааны арга зүй .....	20
2.3. Хувьсах соронзон орон үүсгэх төхөөрөмж.....	21
<b>ГУРАВ. ФЕРРИТ НАНО МАТЕРИАЛЫН ОНОЛЫН СУДАЛГАА</b> .....	25
3.1. Онолын тооцооны аргачлал .....	25
3.2. $MgFe_2O_4$ -ийн онолын тооцооны үр дүн .....	27
3.3. $Y_3Fe_5O_{12}$ , $Y_3Al_5O_{12}$ нэгдлүүдийн онолын судалгаа .....	30
3.4. Дүгнэлт .....	35
<b>ДӨРӨВ. ФЕРРИТ НАНО МАТЕРИАЛЫН БҮТЭЦ, ШИНЖ ЧАНАРЫН СУДАЛГАА</b> .....	36
4.1. Магнийн феррит нэгдлийн судалгаа .....	36
4.2. Зэсийн феррит нэгдлийн судалгаа.....	41
4.3. Зэс-магнийн холимог ( $Mg_{1-x}Cu_x$ ) $Fe_2O_4$ нэгдлийн судалгаа.....	45
4.4. Хөнгөн цагаан-төмрийн $Mg(Al_xFe_{2-x})O_4$ нэгдлийн судалгаа .....	51
4.5. Дүгнэлт .....	55
<b>ТАВ. ФЕРРИТ НАНО МАТЕРИАЛЫН ХЭРЭГЛЭЭ</b> .....	57
5.1. Хорт хавдрын өнөөгийн тоо баримт.....	57
5.2. Хорт хавдрын эмчилгээний аргууд.....	58
5.3. Гипертерм эмчилгээний зарчим.....	61
5.4. Феррит нэгдлийг хаврын эмчилгээнд туршсан судалгаа.....	62
5.5. Дүгнэлт .....	69

## НЭГ. СОРОНЗОН НАНО МАТЕРИАЛЫН ОНЦЛОГ

### 1.1. Шпинел феррит нэгдлүүд

Төмрийн исэл  $\text{Fe}_2\text{O}_3$  бусад металлын исэлтэй нэгдэн үүсгэсэн химийн нэгдлийг феррит гэж нэрлэнэ. Феррит нэгдлийг кристалл бүтцээр нь шпинел-феррит, гранат-феррит, гекса-феррит, орто-феррит гэж ангилна. Эдгээрт шпинел-феррит нь кристалл куб тортой, огторгуйн групп  $Fd\bar{3}m$ ,  $M\text{Fe}_2\text{O}_4$ , (M-хоёр валент бүхий металл ион) гэсэн ерөнхий томьёотой, гранат-феррит куб бүтэцтэй, огторгуйн групп  $Ia\bar{3}d$ ,  $\text{Me}_3\text{Fe}_5\text{O}_{12}$  (Me-газрын ховор элемент) ерөнхий томьёотой, гекса-феррит нь гексагональ тортой, огторгуйн групп  $P63/mmc$ ,  $\text{MeFe}_{12}\text{O}_{19}$  ерөнхий томьёотой, орто-феррит төрөл нь ромбо кристалл тортой, огторгуйн групп  $R\bar{3}m$ ,  $\text{MeFe}_3\text{O}_4$  ерөнхий томьёотой нэгдлүүд байдаг.

Шпинел бүтэц нь  $A^{2+}B_2^{3+}O_4^{2-}$  (A, B нь металл ионууд, O хүчилтөрөгчийн ион) гэсэн ерөнхий томьёотой байдаг агаад  $\text{MgAl}_2\text{O}_4$  минералын нэрээр “шпинел” гэж нэрлэжээ. Бүтцийн хувьд 8 томьёоны нэгжтэй, эгэл торондоо нийт  $8 \times 7 = 56$  ионтой. Хүчилтөрөгчийн ионууд (радиус ойролцоогоор 0.13нм) талд төвлөсөн куб байрлалд багцлагдаж, харьцангуй жижиг металл ион (радиус ойролцоогоор 0.07 – 0.08нм) нь тэдгээрийн хоорондох зайд байрлана (Зураг 1.1). Энэ зай нь 2 янз байдаг. Эхнийх нь тетраэдр буюу A байрлал, энэ байрлал нь булангуудад нь хүчилтөрөгчийн ионууд суусан дөрвөн талтын төвд байрлана. Хоёрдох нь октаэдр буюу B байрлал, энэ байрлал нь булангуудад нь хүчилтөрөгчийн ионууд суусан найман талтын төвд байрлана [3].



Зураг 1.1. Феррит нэгдлийн кристалл бүтэц


Шпинел бүтцийн шинж чанар эгэл тор доторх катионы түгэлтээс ихээхэн хамааралтай байдаг.  $(A_{(1-\delta)}^{(2+)}Fe_{\delta}^{(3+)})^{Tet}(A_{\delta}^{(2+)}Fe_{(2-\delta)}^{(3+)})^{Oct}O_4$  ерөнхий томъёотой шпинел бүтцийн бүх боломжит байрлалууд металл ионоор дүүргэгддэггүй, тетраэдр (A) ба октаэдр (B) байрлалд ионууд холилдон байршина. Түүний харьцааг инверсийн параметр гэж нэрлэдэг  $\delta$  хэмжигдэхүүн тодорхойлно. Уг параметр  $0 \leq \delta \leq 1$  утга авна. Тухайлбал, зөвхөн A байрлалын 1/8, B байрлалын 1/2 нь дүүргэгдсэн байна (Хүснэгт 1.1).  $MFe_2O_4$  ерөнхий томъёотой бүтцийн, бүх металлын ион  $M^{2+}$  нь A байрлалд,  $Fe^{3+}$  нь B байрлалд ( $\delta = 0$ ) байвал энэ бүтцийг энгийн (нормаль) шпинел гэнэ. Урвуу шпинел ( $\delta = 1$ ) гэдэгт хоёр валент бүхий  $M^{2+}$  ионууд B байрлалд, харин гурван валент бүхий  $Fe^{3+}$  ионууд A, B байрлалд хуваагдан байрладаг.  $MFe_2O_4$  (M=Fe, Co, Ni) төмөр, кобальт, никел ферритүүд нь урвуу бүтэцтэй бөгөөд бүгд феррисоронзон юм. Шпинел бүтэцтэй нэгдлүүдийг рентген болон нейтрон дифракцын аргаар судлахад ихэнх тохиолдолд дундын бүтэц  $0 \leq \delta \leq 1$  ажиглагддаг тул энгийн болон урвуу бүтцийг онцгой нөхцөл гэж үздэг.

**Хүснэгт 1.1.**  $MO \cdot Fe_2O_3$  ферритийн тор дахь металл ионуудын түгэлт

Байрлал	Боломжит тоо	Байрлах тоо	Байрлах ион	
			Энгийн шпинел	Урвуу шпинел
Тетраэдр A)	64	8	$8M^{2+}$	$8Fe^{3+}$
Октаэдр B)	32	16	$16Fe^{3+}$	$8Fe^{3+}$ $8M^{3+}$

Феррит материалын соронзон бүтцийг Зураг 1.2-т үзүүлэв. Ерөнхийдөө AB, AA, BB харилцан үйлчлэлүүд нь бүгд сөрөг шинж чанартай байдаг ч энэ нь нэгэн зэрэг тийм байх боломжгүй юм. AB харилцан үйлчлэл нь хамгийн хүчтэй ба бүх A моментууд нь хоорондоо параллель бөгөөд B моментуудтай эсрэг параллель байх зүй тогтолтой.  $CoFe_2O_4$  нэгдлээс бусад бүх ферритийн моментуудын кристаллографийн чиглэл нь  $\langle 111 \rangle$  байх ба энэ нь эгэл торын диагональ дагуу гэсэн үг.  $CoFe_2O_4$  нэгдлийн хувьд моментууд нь куб торын  $\langle 100 \rangle$  чиглэлтэй параллель байдаг.

$\text{NiFe}_2\text{O}_4$  нэгдлийн Ni-ийн хувьд бүтэц нь урвуу  $\text{Ni}^{2+}$  ионууд В байрлалд,  $\text{Fe}^{3+}$  ионууд нь А, В байрлалд тэнцүү хуваагдан байрлана. Иймээс  $\text{Fe}^{3+}$  моментууд усталцаад, Ni-ийн моментууд нийт моментыг бүрдүүлнэ ( $2\mu_B$ ). Эндээс үзэхэд урвуу шпинел ферритийн хувьд дивалент ионы момент нь соронзон ханалтыг илэрхийлнэ. Мөн Mn ферритийн хувьд урвуу биш ч нийт момент нь  $5\mu_B$  гэж гардаг ба энэ нь  $\text{Mn}^{2+}$ ,  $\text{Fe}^{3+}$  аль аль нь  $5\mu_B$  моменттой тул А, В -д хэрхэн тархсанаас үл хамааран  $5\mu_B$  байна. Харин Zn феррит нь энгийн бүтэцтэй, 0 моменттой  $\text{Zn}^{2+}$  ионууд А байрлалыг дүүргэн байрлана (Хүснэгт 1.2). Иймд АВ харилцан үйлчлэл байхгүй.



**Зураг 1.2.** Феррит материалын соронзон бүтэц

**Хүснэгт 1.2.** Феррит нэгдлүүдийн соронзон моментын утгууд

Феррит	$\text{MnFe}_2\text{O}_4$	$\text{FeFe}_2\text{O}_4$	$\text{CoFe}_2\text{O}_4$	$\text{NiFe}_2\text{O}_4$	$\text{CuFe}_2\text{O}_4$	$\text{ZnFe}_2\text{O}_4$
Хэмжсэн $\mu_B$	5	4	3	2	1	0
Тооцоолсон $\mu_B$	4.6	4.1	3.7	2.3	1.3	0

Сөрөг ВВ харилцан үйлчлэлээр В байрлал дахь  $\text{Fe}^{3+}$  ионууд антипараллел, нийт моментгүй болно (Зураг 1.3). Эндээс Zn нь антиферросоронзон материал гэж үзэж болох ба энэ нь зөвхөн 9К-ээс бага температурт л ийм шинж чанартай.



**Зураг 1.3.** А болон Б байрлал дахь төмрийн соронзон моментийн чиглэлийн хамаарал

ВВ харилцан үйлчлэл маш сул бөгөөд багахан дулааны энерги ч моментуудыг антипараллел жагсахад саад болдог. А, В байрлал дахь моментууд нь антипараллел байдаг ба үүнийг Хүснэгт 1.3. -т харуулав.

**Хүснэгт 1.3. Зарим ферритийн хувьд ион тархалт болон нийт соронзон момент**

Жишээ	Бүтэц	Материал	Тетраэдр		Октаэдр		Нийт момент ( $\mu_B$ /молекул)
			А байрлал		В байрлал		
1	Урвуу	$NiFe_2O_4$	$Fe^{3+}$		$Ni^{2+}$	$Fe^{3+}$	2
		Тоо ширхэг	5		2	5	
		Чиглэл	→		←	→	
2	Энгийн	$ZnFe_2O_4$	$Zn^{2+}$		$Fe^{3+}$	$Fe^{3+}$	0
			0		5	5	
					←	→	
3	Бараг урвуу	$MgFe_2O_4$	$Mg^{2+}, Fe^{3+}$		$Mg^{2+}$	$Fe^{3+}$	1
		Тоо ширхэг	0	4.5	0	5.5	
		Чиглэл	→			←	
4	Урвуу	$0.9NiO Fe_2O_3$	$Fe^{3+}$		$Ni^{2+}$	$Fe^{3+}$	1.8
		Тоо ширхэг	4.5		1.8	4.5	
		Чиглэл	→		←	←	
	Энгийн	$0.1ZnO Fe_2O_3$	$Zn^{2+}$		$Fe^{3+}$	$Fe^{3+}$	1.0
		Хэмжээ	0		0.5	0.5	
		Чиглэл			←	←	
		Тоо ширхэг	4.5		7.3		2.8
		Чиглэл	→		←		

Магнийн феррит  $MgFe_2O_4$ -ийг сонирхъё. Mg нь бүрэн урвуу биш учир дивалент ион болох  $Mg^{2+}$  ион нь нийт 0 моменттой байдаг. Учир нь  $Mg^{2+}$  ионы 0.1 нь А байрлалд байдаг ба ингэснээр А байрлал дахь ион  $0.9 \times (5) \mu_B = 4.5 \mu_B$  болох ба харин В байрлалынх  $1.1 \times (5) \mu_B = 5.5 \mu_B$  болж нийт момент  $1 \mu_B$  болно. Энэ нь туршлагын утгатай ( $1.1 \mu_B$ ) таардаг.

Цайр агуулсан холимог ферритүүдийн хувьд нэг сонирхолтой зүйл нь соронзжилтгүй  $Zn^{2+}$ -ийн нэмэлт нь соронзон моментыг ихэсгэдэг. Үүнийг (Хүснэгт 1.3.) 4 дэх жишээн дэх 10 мол% Zn феррит агуулсан 90 мол% Ni –ийн холимог ферритийн нийт моментоос харж болно. 0 моменттой  $Zn^{2+}$ -ийн ионууд цэвэр Zn –ийн ферритийн адил А байрлалд очсоноор А байрлалын момент суларч, Zn ферритийн  $Fe^{3+}$  ионууд хүчтэй АВ харилцан үйлчлэлээр В байрлал дахь моменттой параллель моменттой болно. Ингэснээр нийт момент цэвэр Ni ферритийн хувьд  $2.0\mu_B$  байдаг, холимог ферритийн хувьд  $2.8\mu_B$  болж өсдөг. Хэрэв ийм байдлаар 10 мол% тутамд  $0.8\mu_B$  –аар өсөж байвал цэвэр Zn феррит  $10\mu_B$  моменттой байхаар харагдаж байна.

Феррит шпинел нэгдлийн соронзон шинж чанар нь ион бүрийн соронзон момент, А, В байрлал дахь ионуудын түгэлт, харилцан үйлчлэлээс хамаарна. Бидний судалгаагаар холимог кристалл бүтэц бүхий  $Mg_{1-x}Cu_xFe_2O_4$  нэгдлийн соронзон шинж чанар нь  $MgFe_2O_4$  ба  $CuFe_2O_4$  нэг төрлийн шпинел бүтэц бүхий нэгдлээс эрс ялгаатай байдаг (Хүснэгт 1.4).

**Хүснэгт 1.4.** Ферритүүд дэх соронзон болон бусад өгөгдлүүд


Нэгдэл	Торын параметр, а (нм)	Нягт (г/см <sup>3</sup> )	0К		20° С		T <sub>c</sub> (°С)
			$\sigma_0$ (эму/г)	M <sub>0</sub> (эму/см <sup>3</sup> )	$\sigma_s$ (эму/г)	M <sub>s</sub> (эму/см <sup>3</sup> )	
MnFe <sub>2</sub> O <sub>4</sub>	0.85	5.00	112	560	80	400	300
FeFe <sub>2</sub> O <sub>4</sub>	0.839	5.24	98	510	92	480	585
CoFe <sub>2</sub> O <sub>4</sub>	0.838	5.29	90	475	80	425	520
NiFe <sub>2</sub> O <sub>4</sub>	0.834	5.38	56	300	50	270	585
CuFe <sub>2</sub> O <sub>4</sub>	0.837 <sup>a</sup>	5.41	30	160	25	135	455
MgFe <sub>2</sub> O <sub>4</sub>	0.836	4.52	31	140	27	120	440
BaFe <sub>2</sub> O <sub>4</sub>	a=0.588 c=2.32	5.28	100	530	72	380	450
Fe	0.287	7.87	222	1747	218	1714	770

## 1.2. Феррит нано материалын дулаан ялгаруулах үзэгдэл

Феррит  $MFe_2O_4$  ( $M = Mn, Ni, Co, Cu, Mg, Ni, Fe$ ) соронзон нано бөөмсийн (ихэвчлэн 5-100 нм хэмжээтэй) соронзон шинж чанар нано бөөмсийн хэмжээ, хэлбэрээс хамаардаг онцлогтой учир хими, физик, биологийн шинжлэх ухааны огтлол дээр ихээхэн сонирхол татаж байна. Түүнээс гадна нано хэмжээсийн орчимд соронзонд байдаг коэрцитив хүч ( $H_c$ ), ханалтын соронзжилт ( $J_s$ ) ба соронзон мэдрэх чадвар ( $\chi$ ) зэрэг хэмжигдэхүүн нь соронзон нано бөөмийн хэмжээ, хэлбэр, бүтэц зэргээс хүчтэй хамаарч байдаг. Энэхүү өвөрмөц соронзон шинж чанар, жижиг хэмжээ, био нийцтэй байдал зэрэг нь тэдгээрийг тухайлбал, соронзон резонансын дүрслэл (MRI)-ийн тодосгогч байдлыг сайжруулах, эмийн бодисын нано хэмжээт зөөгч болгох, цахилгаан соронзон энергийг дулааны энергид хувиргах, соронзон чиглүүлэгч ба био мэдрэгч бодис болгох зэргээр био-анагаахын салбарт төрөл бүрийн зориулалтаар өргөнөөр ашиглах боломж олгодог [4].

Орчин үед хавдрыг эмчлэх янз бүрийн аргууд хэрэглэж байгаа боловч, бусад эрхтэнд гэмтэл учруулахгүйгээр эмчилгээ хийх үр дүнтэй арга хараахан нээгдээгүй байна. Тэгвэл хавдрын халуун эмчилгээ буюу “hyperthermia” нь соронзон нано бөөмийг өвчний голомтод хүргэж, өндөр давтамжтай хувьсах соронзон оронгоор үйлчилснээр, дулаан ялгаруулж бусад эрүүл эсэд нөлөөлөлгүй зөвхөн хавдрын эсийг устгадаг дэвшилтэт арга юм. Энэ аргад соронзон феррит материалуудыг хэрэглэж жижиг биетэй амьтдын хавдрыг амжилттай эмчилж байгаа боловч хүний биед хэрэглэхэд хангалттай хэмжээний дулаан ялгаруулж чадахгүй дутагдалтай тал илэрсэн [5-7].

Өмнө хийгдсэн судалгааны үр дүнгүүдээс үзэхэд  $MgFe_2O_4$  феррит нэгдэл нь бусад феррит нэгдлүүдтэй харьцуулахад хувьсах соронзон оронд хамгийн их дулаан ялгаруулж байсан (Зураг 1.4). Тухайн нэгдлийн дулаан ялгаруулах чадамжид бөөмийн хэмжээ, морфологи, кристалл болон соронзон бүтцээс гадна тетраэдр болон октаэдр байршил дахь ионуудын түгэлт зэрэг нь чухал нөлөөтэй болох нь өмнөх судалгаануудаар тогтоогдсон байна.



**Зураг 1.4.** Феррит материалуудын дулаан ялгаруулах чадамж

Холимог шпинел ферритийн тохиолдолд хоёр ба түүнээс дээш катионыг агуулах бөгөөд тухайн материалуудын шинж чанарыг өөрчлөн сайжруулах боломжийг олгодог байна.  $MgFe_2O_4$  нэгдлийг  $Ca, Sr, Cu, Mn, Si, Ni$  элементүүдээр хольцлон шинж чанарыг нь сайжруулах судалгаанууд хийгдээд байна.

### 1.2.1. Неелийн болон Брауны релаксац

Ихэнх тохиолдолд нано бөөмсийн соронзжилт жигдэрсэн тэр чиглэлүүдэд шинж чанар нь үргэлж давуу байдаг бөгөөд эдгээр чиглэлд нанобөөмс анизотроп шинжтэй гэж үздэг. Хэрэв зөвхөн нэг чиглэл илүү давамгайл бол нэг тэнхлэгт анизотроп гэж ярьдаг. Нэг тэнхлэгт анизотроп шинжтэй нано бөөмсийн хувьд дулааны энергийн нөлөөгөөр санамсаргүй байдлаар соронзжилтын чиглэл сонгон байршихыг эрмэлзэн “савлана”. Энэ процесс нь нэгдүгээрт, соронзон моментын чиглэл өөрчлөгдөх, хоёрдугаарт, бөөм өөрийн тэнхлэгээ тойрон эргэх гэсэн 2 төрлийн механизмаар явагддаг. Тэдгээрийг Неел (Néel relaxation) ба Браун (Brownian relaxation) процесс гэж нэрлэнэ. Энэ савлах эффектийн дундаж хугацаа нь релаксацын хугацаа гэж нэрлэгддэг  $\tau$ -аар тодорхойлогдоно [8]:

$$\tau = \tau_0 \exp\left(\frac{E_a}{k_B T}\right). \quad (1.1)$$

Энд  $\tau_0$  – судалж байгаа материалаас хамаарах тогтмол хугацаа. Энэ хэмжигдэхүүний утга нь  $10^{-9}$ - $10^{-12}$  сек.  $E_a = KV$  нь дулааны энергийн тусламжтайгаар давж соронзжилт

явагдах энергийн саад буюу анизотроп энерги,  $V$ - нано бөөмийн эзлэхүүн,  $k_B$ - Больцманы тогтмол,  $T$ -температур.

Аливаа физик хэмжигдэхүүнийг хэмжиж байгаа хэмжилтийн багаж төхөөрөмж нь тухайн физик утгыг хамгийн бага хугацаанд хэмжиж амжих  $t_m$  хэмжилтийн хугацаатай байдаг. Савлалтын хоорондох дундаж хугацаа хэмжилтийн хугацаанаас их байвал  $t_m \ll t$  нано бөөмс цоожлогдсон (блоклогдсон) төлөв байдал гэж нэрлэгдэх тодорхой төлөвт орно. Савлалтын хоорондох дундаж хугацаа хэмжилтийн хугацаанаас олон дахин бага  $t_m \gg t$  байвал хэмжилтийн явцад соронзжилтын янз бүрийн чиглэл тогтож амжихгүй байгаа флуктуац төлөвүүдийг ажиглаж чадахаас гадна хугацаагаар дундажлагдсан соронзон моментыг хэмжиж болно. Ийм төлөв байдлыг системийн супер парасоронзон төлөв гэж нэрлэдэг. Хэмжилтийн хугацаа ажиглагдах төлөв байдалд их хэмжээгээр нөлөөлдөг ч зарим хэмжилтийн хугацаа ямар хэмжээтэй байдгийг мэдэхэд илүүдэхгүй. Тогтмол соронзон оронд 100 сек., хувьсах соронзон оронгийнх  $10^{-1}$  -  $10^{-5}$  сек., Мёссбауэрийн спектроскопт  $10^{-7}$  -  $10^{-9}$  сек. байна.

Хувьсах соронзон оронд байгаа соронзон бөөмийн хувьд гадны соронзон орон, мөн өөрийн дотоод соронзон оронгийн харилцан үйлчлэлийн үр дүнд энерги (дулаан) ялгарна. Нано хэмжээст соронзон материалд дулаан ялгарах үзэгдэл нь соронзон бөөм доторх соронзон моментын чиглэл өөрчлөгдөж эргэн сэргэх Неелийн процесс болон уг бөөм өөрийн тэнхлэгээ тойрон эргэх Брауны процесстой уялдан үүснэ. Гаднын хувьсах оронгийн давтамжаас хамааран өөрчлөгдөх хугацаа нь соронзон бөөмийн дотоод оронгийн эргэн сэргэх хугацаа (relaxation time)-аас бага байна.

### 1.2.2. Соронзон нано бөөмийн ялгаруулах дулаан

Нано бөөмийн хэмжээ ихсэхэд релаксацийн хугацаа ихэснэ. Шилжилтийн хугацаа  $t_N = t_m$  үед харгалзах  $T_B$ -температурыг супер парасоронзон хаалтын температур гэж нэрлээд дараах томъёогоор тодорхойлно:

$$T_B = \frac{KV_M}{k_B \ln \left( \frac{t_m}{\tau_0} \right)}. \quad (1.2)$$

Нано бөөмийн хэмжээ ихсэхэд супер парасоронзон шилжилтэд шаардлагатай  $k_B T$  дулаан их болно. Эндээс  $T_B$  их байх тутам бөөмийн хэмжээ их байна гэдгийг дээрх томъёо харуулж байна. Нано бөөмсийн харилцан үйлчлэл Вогель-Фулчерийн загвар ёсоор дараах зүй тогтолтой [9]:

$$\tau = \tau_0 \exp\left(\frac{E_a}{k_B(T-T_0)}\right). \quad (1.3)$$

Энд:  $T_0$  Вогель-Фулчерийн температур.

### 1.2.3. Анизотроп ба соронзон мэдрэх чадвар

Соронзон нано бөөмс соронзон оронгийн үйлчлэлээр соронзжилт эргэн хувьсан өөрчлөгдөх процессод орж улмаар цахилгаан соронзон энергийг дулааны энерги болгон хувиргадаг [10]. Соронзжилт эргэн өөрчлөгдөх үзэгдэл гистерезисийн алдагдал (ферросоронзон нано бөөмс) ба соронзон мэдрэх чадварын алдагдал (супер парасоронзон нано бөөмс) гэсэн хоёр төрлөөр явагдана. Гистерезисийн алдагдал нь соронзон оронгийн далайц ( $H_{ac}$ ), мөн коэрцитив хүч ( $H_c = 2K/\mu_0 M_s$ ) -ээс хамаарна.

Хэрэв хувьсах соронзон орон  $\mu$  соронзон момент бүхий ферросоронзон нано бөөмд үйлчлэхэд соронзон төлөв мета төлөв байдалд оршино. Үүний дүнд соронзон момент чиглэлээ өөрчлөн эргэж энерги (Зееман энерги) нь  $+\mu_0 \mu H_k$  утгаас  $-\mu_0 \mu H_k$  болж  $2\mu_0 \mu H_k$  хэмжээний энерги дулаанд хувирна. Хувийн дулаан алдагдал  $P_H$  нь  $4\mu_0 \mu H_k f \Phi^{-1}$  буюу  $4\mu_0 M_s K f \rho^{-1}$  гэж тодорхойлогдоно. Энд,  $\Phi$  ба  $\rho$  нь нано бөөмийн жин, нягт. Нано бөөмийн Неелийн релаксацийн хугацаа  $\tau_N$  анизотроп энергиэр, Брауны релаксацийн хугацаа  $\tau_B$  нь гидродинамик эзлэхүүн ба орчны зуурамтгай чанараар, эдгээрийн нийлбэр эффе́ктив ( $\tau$ ) хугацаа дараах тэгшитгэлүүдээр тодорхойлогдоно.

$$\tau_N = \tau_0 \exp\left(\frac{KV_M}{k_B T}\right), \quad (1.4)$$

$$\tau_B = \frac{3V_H}{k_B T} \eta, \quad (1.5)$$

$$\frac{1}{\tau} = \frac{1}{\tau_B} + \frac{1}{\tau_N} \quad \text{буюу} \quad \tau = \frac{\tau_B \tau_N}{\tau_B + \tau_N}$$

$$\tau = \frac{M_S}{2\gamma_0 K} \left( \frac{\pi k_B T}{V_M} \right) \exp \left( \frac{KV_M}{k_B T} \right). \quad (1.6)$$

Энд,  $\tau_0$ - тогтмол хэмжигдэхүүн, ойролцоогоор  $10^{-9}$  сек,  $K$  – анизотроп тогтмол,  $V_M$  - бөөмийн эзлэхүүн,  $k_B$  -Больцманы тогтмол,  $T$ -температур,  $\eta$ - зуурамтгайн коэффициент,  $V_H$ - бөөмийн гидродинамик эзлэхүүн.

Хувьсах соронзон оронд феррит нано бөөмийг оруулахад ялгарах чадал (дулааны хэмжээ)  $P$  дараах илэрхийллээр тодорхойлогдоно:

$$P = \frac{(\mu H \omega \tau)^2}{[2\tau k_B T \rho V (1 + \omega^2 \tau^2)]}. \quad (1.7)$$

Энд,  $\mu$ - бөөмийн соронзон момент,  $H$ - соронзон оронгийн хүчлэг,  $\omega$ - оронгийн өнцөг давтамж,  $\rho$ - нано материалын нягт.

Супер парасоронзон бөөмийн хувьд эзлэхүүн  $V_H$  багасахад  $\tau_V$  хугацаа түүнтэй шууд пропорционалаар багасах учир  $\tau$  хугацаа зөвхөн  $\tau_H$  хэмжигдэхүүнээр тодорхойлогдоно. Энэ тохиолдолд комплекс мэдрэх чадварын байгуулагч  $\chi''$  дараах томъёогоор бичигдэнэ:

$$\chi'' = \frac{\mu_0 \mu^2}{3k_B T} \left( \frac{\omega \tau}{1 + (\omega \tau)^2} \right). \quad (1.8)$$

Эндээс дараах илэрхийллийг гарган авч болно [7]:

$$P = \pi \mu_0 \chi'' H_{ac}^2 f \rho^{-1} = \frac{\pi \mu_0 \chi'' H_{ac}^2}{3\rho k_B T} \frac{2\pi f^2 H_{ac}^2 \tau}{[1 + (2\pi f \tau)^2]}. \quad (1.9)$$

Эцэст нь дүгнэн хэлэхэд, суперпара соронзон материалын хувьд  $M_S$  хэмжигдэхүүн их утгатай,  $K$  дундаж утгатай байвал хамгийн тохиромжтой гэж үзэж болно.

### 1.3. Дулаан ялгарах үзэгдлийг судлах арга зүй

Соронзон материалын хувьсах соронзон оронд дулаан ялгаруулах чадамжийг Хувийн Шингээх Чадал (XШЧ-specific absorption rate-SAR) гэсэн хэмжигдэхүүнээр тодорхойлдог. Энэ нь дээжийн нэгж масс дахь шингээсэн энерги (Вт/г) юм. XШЧ -г дараах үндсэн 3 аргаар тодорхойлдог. Үүнд: Дулаан хэмжилтийн арга, Соронзон хэмжилтийн арга, Аналитик арга.

Эхний аргад соронзон материалыг хувьсах соронзон оронд оруулан ялгарах дулааныг хэмждэг. Энд ялгарах дулаан болон температурын өсөлт хоорондын хамаарлаар ХШЧ –г тооцдог [9]. Харин хоёр дахь аргад соронзон хэмжилтээс дээжийн соронзон ханалтын утга болон гистерезисийн алдагдлыг тооцоолж олдог [11]. Сүүлийн буюу гурав дахь аргад ХШЧ –г тооцоолохдоо соронзон орны хүч, давтамж мөн тухайн материалын цөмийн хэмжээ, гидродинамик хэмжээ, анизотроп тогтмол зэрэг шинж чанаруудаар нь тодорхойлдог [11].

Дээрх аргуудаас дулаан хэмжилтийн арга нь хамгийн түгээмэл хэрэглэгддэг. Хувийн шингээх чадал гэх нэр томъёо нь цахилгаан соронзон долгион (хэт авиа)-ны үйлчлэлд буй биологийн эд эсийн нэгж эзлэхүүнд шингэх чадлыг илэрхийлнэ. Бидний авч үзэж буй тохиолдолд буюу соронзон материалын хувьд энэ хэмжигдэхүүн соронзон материалын нэгж массаас ялгарах дулааны чадлыг илэрхийлнэ. Иймд ХШЧ –ыг дараах томъёогоор тодорхойлно:

$$\text{ХШЧ} = \frac{c}{m} \frac{\Delta T}{\Delta t} \quad (1.10)$$

Энд, *c*-нано материал агуулсан коллоид шингээний хувийн дулаан багтаамж (усны хувьд  $c = 4.18 \text{ Ж}/(\text{г} \cdot \text{град})$ ),  $\frac{\Delta T}{\Delta t}$ -температурын хугацааны өөрчлөлт, *m* – соронзон материалын масс (г/мл).

Нано соронзон бөөмөөс үүсгэх дулааны тоо хэмжээг хувийн шингээх чадлаас гадна хувийн дулаан алдагдал (specific loss power-SLP), гэсэн хэмжигдэхүүнээр тодорхойлно [12]. Хэмжих нэгж нь Вт/кг байна. Хувийн дулаан алдагдал (ХДА)-ыг дараах харьцаагаар тооцоолдог [13]:

$$\text{ХДА} = \frac{c}{m} \frac{\Delta T}{\Delta t} \quad (1.11)$$

Соронзон гипертерм ойлголтын хүрээнд ХШЧ (1.10) ба ХДА (1.11) ижил хэмжигдэхүүнүүд байдаг. ХДА ойлголт нь өндөр давтамжийн долгион хүний биед хэрхэн шингээгдэх вэ гэдгийг тодорхойлдог учир Соронзон гипертерм салбарт хэрэглэгдэх нам буюу харьцангуй бага давтамжийн долгионы хувьд төдийлөн тохиромжгүй, нөгөө талаас “дулаан шингээлт” гэсэн ойлголт энэ салбарт тохирдоггүй. ХШЧ хэмжигдэхүүн нь нормчлогдсон массын хувьд ялгарч буй чадлын хэмжээг (хүч) илүү их нарийвчлалтай илэрхийлдэг байна.


## ХОЁР. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### 2.1. Феррит nano материал гарган авах аргууд

Орчин үед феррит nano материал гарган авах олон төрлийн синтезийн аргууд ашиглагдаж байна. Үүнд химийн тунадасжилт, золь-гель, хатуу төлөвийн урвалын арга, гидротермал, электрохимийн гэх мэт олон аргууд бий. Эдгээр нь бүгд өөр өөрийн давуу болон сул талуудтай [14]. Энэ төслийн хүрээнд бид хатуу төлөвийн урвалын арга болон золь-гель аргуудыг ашиглан судалгааны дээжүүдийг гарган авсан.

#### 2.1.1. Хатуу төлөвийн урвалын арга

Хатуу төлөвийн урвалын арга нь химийн урвалжуудыг механик арга (ball mill)-аар нунтаглан холих замаар поликристалл материалыг гарган авах нилээн нийтлэг синтезийн арга юм. Уг урвал явагдахын тулд ихэвчлэн маш өндөр температурыг ашигладаг. Хатуу төлөвийн урвалд нөлөөлөх хүчин зүйлс нь урвалжуудын химийн болон морфологийн шинж чанар, түүний дотор урвалын идэвхжил, гадаргуугийн талбай, хатуу төлөвийн температур, даралт, орчин зэрэг урвалын нөхцөлүүд юм. Хатуу төлөвийн урвалын аргын давуу тал нь энгийн бөгөөд дээжийг их хэмжээгээр гарган авах боломжтой юм [15].




Зураг 2.1. Хатуу төлөвийн урвалын процессийн схем

#### 2.1.2. Золь-гель арга

Золь-гель аргын давуу тал нь өртөг бага, кристалжилтын хэмжээ нэгэн төрөл, цэвэршилт сайтай гарган авах боломжтой юм [16]. Золь-гель аргаар материал гарган авахад “золь” болон “гель” гэсэн хоёр фазыг дамжин дээжийг гарган авдаг.

“Золь” нь дээжийн шингэн орчин дахь коллоид уусмал юм. Нунтаг дээжийг золь-гелийн аргаар гарган авахад металл ионы нитрат болон усанд амархан уусдаг глицин, нимбэгний хүчил зэргийг металл ионуудын холбогчоор ашигладаг. Металл нитрат болон цитратын харьцаа 1:х байдаг (х нь ихэнх тохиолдолд 1 – 3). Давхар нэрсэн, ионгүйжүүлсэн усанд нитратуудыг уусгана. Уг нитрат болон нимбэгний хүчлийг усанд уусгахдаа өндөр градуст тасралтгүй хутгалттайгаар уусмал болгоно. Усны молекулууд ууршиж дуусахад уусмал зуурамтгай гель хэлбэрт орно [17].

Улмаар гелийг өндөр температурт шатааснаар дээж бэлэн болно. Золь-гель процессын схемийг зураг 2.2-т үзүүлэв. Нитрат болон металл ионуудын холбогч хоорондын харьцаа нь бөөмийн хэмжээ болон соронзон шинж чанарт нөлөөлдөг болохыг судалгаагаар тогтоогоод байна [18].



Зураг 2.2. Золь-гель процессийн схем

## 2.2. Бүтцийн судалгааны арга зүй

**Рентген дифракцын арга (XRD):** Рентген туяаны дифракц (XRD) нь материалын фазын агуулга, кристалл бүтэц, химийн найрлага, физик шинж чанарын талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгдөг техник юм. Судалгааны ажилд ФТХ ийн Shimadzu брэндийн  $\text{CuK}\alpha$  анод бүхий Maxima\_X XRD-7000 дифрактометрийг ашигласан.

**Нейтрон сарнилын арга:** Нейтрон нь бодис дахь атомын гүнд очиж цөмтэй харилцан үйлчилдэг учир хөнгөн цөм Li, H гэх мэт рентгенээр тодорхойлох боломжгүй элементүүдийг судлах боломжийг бидэнд олгодог. Нейтронографийн өгөгдлийг боловсруулснаар кристалл тор дахь атомын цөмийн түгэлтийг дэлгэрэнгүй тодорхойлох боломжтой. Нейтрон нь соронзон моменттой учир атомын цөмийн болон электроны спинтэй харилцан үйлчилж кристаллын соронзон бүтцийн дүр зургийг тодорхойлдог давуу талтай. Энэ төслийн хүрээнд Дубна дахь Цөмийн шинжилгээний нэгдсэн институт (ЦШНИ)–ийн IBR-2 реактор дээр өндөр ялгах чадвар бүхий нейтрон дифрактометр (Фурье дифрактометр) - ийг ашиглан кристалл болон соронзон бүтцийн судалгааг гүйцэтгэсэн.



**Зураг 2.3.** Олон улсын Цөмийн Шинжилгээний Нэгдсэн Институтийн Нейтроны физикийн лабораторийн Өндөр ялгах чадвар бүхий Фурье дифрактометр


**Хэт ягаан туяаны спектроскоп (UV-Vis):** Хэт ягаан туяаны спектроскоп нь дээжид шингэсэн эсвэл дамжин өнгөрсөн хэт ягаан туяа эсвэл үзэгдэх гэрлийн салангид долгионы уртыг хоосон дээжтэй харьцуулан хэмждэг аналитик арга юм.

Судалгааны ажилд Shimadzu брэндийн UV 2550 спектрофотометр ашиглан хэмжилтийг явуулав.

**Нил улаан туяаны спектроскоп (FTIR):** Нил улаан туяаны спектроскоп нь органик, полимер, зарим тохиолдолд органик бус материалын агуулгыг тодорхойлоход ашигладаг аналитик арга юм. Судалгааны ажилд долгионы уртын  $500-4000\text{ см}^{-1}$  мужид Shimadzu брэндийн IR Prestige-21 спектрометр ашиглан хэмжилтийг явуулав.

### 2.3. Хувьсах соронзон орон үүсгэх төхөөрөмж

Соронзон nano материалаас дулаан ялгарах үзэгдлийг судлах зорилгоор бид эхний ээлжид хувьсах соронзон орон үүсгэх төхөөрөмжийг өөрсдөө угсарч суурилуулсан.



**Зураг 2.4.** а) Бидний угсарсан хувьсах соронзон орон үүсгэх төхөөрөмж, б) БНХАУ-д үйлдвэрлэсэн өндөр давтамжийн индукцийн халаалтын төхөөрөмж, в) төхөөрөмжийн бүдүүвч зураг

Өндөр давтамжийн индукцийн халаалтын төхөөрөмжийн зарчим нь өндөр давтамжийн хувьсах гүйдлийн урсгалыг зэс ороомгоор дамжуулан индукцийн гүйдэл үүсдэг (eddy current). Энэхүү хувьсах гүйдлийн нөлөөний улмаас дулаан үүсгэдэг тул халаалтын энэ аргыг индукцийн халаалт гэж нэрлэдэг. Индукцийн халаалт нь зэс ороомгийн төв хэсэгт хамгийн их хүчтэй явагддаг. Бидний угсарсан хувьсах соронзон орон үүсгэх төхөөрөмж нь 71 кГц-ийн давтамжийг үүсгэж байсан бөгөөд төмөр агуулсан нано соронзон бодисын дулаан ялгарах хэмжилтийг усан орчинд тасалгааны температурт хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Дээжүүдийн хувьсах соронзон оронд ялгаруулж буй дулааныг термометр (алкоголь) болон хэт улаан туяаны камерын тусламжтай хэмжсэн. Мөн цаашдын нарийвчилсан судалгаануудад ашиглах зорилгоор Хятад улсын HAIMINGSI компанид үйлдвэрлэсэн өндөр давтамжийн төхөөрөмж ашиглагдаж байна. Зарчмын хувьд дээрх төхөөрөмжтэй ижил боловч 370 кГц хүртэлх өндөр давтамжийн мужид туршилт явуулах боломжтой юм. Угсарсан хувьсах соронзон орон үүсгэх төхөөрөмж, хэмжилтийн ерөнхий бүдүүвчийг зураг 2.4-д, үндсэн параметруудийг хүснэгт 2.1-д үзүүлэв.

**Хүснэгт 2.1.** Хувьсах соронзон орон үүсгэх төхөөрөмжийн параметр

Үндсэн параметрууд	Төхөөрөмж 1	Төхөөрөмж 2
	HAIMINGSI	
Ороомгийн ороодсын тоо	7	7
Ороомгийн дотоод диаметр (мм)	65	65
Давтамж (кГц)	71	370
Чадал (кВт)	2.5	
Усан хөргөлт (л/мин)	7-8	7-9

### 2.3.1. Соронзон орны судалгаа, тооцоо

Угсарсан соронзон төхөөрөмжийн үүсгэх соронзон орныг онолын хувьд тооцоолон загварчлах зорилгоор дараах тооцоог хийж гүйцэтгэлээ. Соленойдийн хувьд соронзон орныг тооцоолохын тулд эхлээд соленойдын нэг ороодсыг авч үзвэл соронзон орны индукц нь доорх томъёогоор илэрхийлэгдэнэ.

$$B = \frac{\mu_0 I a^2}{2r^3} \quad (2.1)$$

Харин ороодсоор гүйх гүйдлийн үүсгэх соронзон орны индукцыг Био-Савар-Лапласын хуулиар:

$$dB = \frac{\mu_0 I a^2}{2r^3} dx \frac{N}{2} = \frac{\mu_0 I a^2 N}{2L} \frac{dx}{((l-x)^2 + a^2)^{3/2}}$$


$$B = \frac{\mu_0 I a^2 N}{2L} \int_0^L \frac{dx}{((L-x)^2 + a^2)^{3/2}}$$

$$B = \frac{\mu_0 I a^2 N}{2L} \left[ \frac{l}{\sqrt{l^2 + a^2}} + \frac{L-l}{(L-l)^2 + a^2} \right]$$

$$B = \frac{\mu_0 I a^2 N}{L} [\cos\vartheta_1 - \cos\vartheta_2] \quad (2.2)$$

гэж бичигдэнэ.

Өөрсдийн угсарсан соронзон төхөөрөмжийн параметрууд болох ороомгийн радиус  $a=3.15$  см, гүйдэл  $I=15$  А, ороодсын тоог  $N=7$  орлуулан соронзон орны индукцийг солнойдын ( $\vartheta_1 = \vartheta_2 = 0$ ) хувьд тооцооллоо (Зураг 2.5).



**Зураг 2.5.** а – солнойдын үүсгэх соронзон орон; б – солнойдын соронзон орны индукц зайнаас хамаарах хамаарал

Ороомгийн голд үүсэх соронзон оронг дараах харьцаагаар тооцоолсон.

$$H = NIa^2 / 2(z^2 + a^2)^{3/2} \quad (2.3)$$

Энд:  $N$ - ороомгийн ороодсын тоо,  $I$ - гүйдэл,  $a$ -ороомгийн радиус,  $z$ -  $z$ -тэнхлэг дээрх ороомгийн төв хүртэлх зайг тус тус илэрхийлнэ. Бидний угсарсан хувьсах

соронзон зэс ороомгийн голд үүсэх соронзон орны хэмжээг (2.3) томъёогоор тооцоолоход  $1.006 \text{ кАм}^{-1}$  гэж тодорхойлогдлоо.

## ГУРАВ. ФЕРРИТ НАНО МАТЕРИАЛЫН ОНОЛЫН СУДАЛГАА

Сүүлийн жилүүдэд Хиразава [19] нарын судлаачид магнийн ферритийн дулаан ялгаруулах шинж чанарт  $Cu$ -ийн ион хэрхэн нөлөөлж байгааг судалсан бөгөөд  $Cu^{2+}$  ионыг хольцолсноор дулаан ялгаруулах чадамж өсөж буйг тогтоосон байна. Энэ нэгдлийн тухай хэд хэдэн судалгааны ажлууд хэвлэгдсэн байдаг боловч  $Mg_{1-x}Cu_xFe_2O_4$ -ийн бүтцийн өөрчлөлтийн тухай маш бага судлагдсан байдаг [20, 21]. Тийм учраас бид био-анагаахын хэрэглээтэй холбоотойгоор  $MgFe_2O_4$ -ийг  $Cu$ -аар хольцлосон нэгдэл болон итри төмрийн гарнет ( $Y_3Fe_5O_{12}$ ) материалуудын онол болон бүтцийн судалгааг хийлээ [22]. Ферритүүдийн кристалл, электрон болон соронзон бүтцийг нейтрон болон рентген дифрактометр, рентген туяаны шингээлтийн спектроскопыг ашиглан хийж, квант механикийн аргаар электрон болон соронзон бүтцийн онолын судалгааг хийв. Судалгааны ажлын зорилго нь феррит материалын дулаан ялгаруулах чадамжийг бүтцээс хамааруулан тайлбарлах явдал юм.

### 3.1. Онолын тооцооны аргачлал

$AB_2O_4$  гэсэн ерөнхий томъёо бүхий нормаль шпинель бүтэцтэй  $MgFe_2O_4$ -ийн ионууд диамонд( $A$ ) ба пироклор( $B$ ) гэсэн дэд торуудад байрлаж (Зураг 3.1) байхаар сонгон НФО-д [23, 24] тулгуурласан хавтгай долгионы псевдо потенциалыг ( $PW_{scf}$ ) [25] сонгон авч өргөтгөсөн градиентын (GGA) аргыг ашиглан QUANTUM ESPRESSO [26] багц программаар тооцоог гүйцэтгэв. Ион ба валентын электрон хоорондын харилцан үйлчлэл нь ультрасофт псевдо потенциалгаар илэрхийлэгддэг. Эдгээр элементүүд гадаад давхраандаа:  $O(2s^2, 2p^4)$ ,  $Mg(2p^6, 3s^1, 3p^{0.75})$ ,  $Fe(3s^2, 3p^6, 3d^{6.5}, 4s^1)$ ,  $Cu(3d^{9.5}, 4s^1, 4p^{0.5})$  орбиталиуд электроноор дүүргэгддэг. Харин долгион функц нь хавтгай долгионоор илэрхийлэгдэх ба кинетик энергийн дээд хязгаарыг 40 Рб (Ридберг) байхаар авч сонгон авсан. Атомын бүтэц, ионы байрлал, торын параметруудийг тодорхойлохын тулд атом бүрийн үлдэгдэл хүчийг 0.05 эВ/Å болтол оптимизац хийв.  $Fe(3d)$  болон  $Cu(3d)$  төлөвүүдэд электронуудын хүчтэй корреляцлах эффект илэрдэг ба Хаббард + Гамильтониан дээр суурилсан солилцол хоорондын соронзон эффектийн параметр ( $J_0$ ) болон Хаббардын параметр  $U = 7,5$ эВ-оор тус тус сонгон авч инвариант шугамчлах аргыг ашиглав.  $J_0$ -ийг шугаман харилцан үйлчлэлийн аргыг ашиглан тооцоолж соронзон ион бүрийг 1эВ

энергитэй гэж үзэв [27]. Атомын долгион функцийг ( $GGA + U + J_0$ ) байхаар сонгон авсан.

Бидний авч үзэж буй бүтэц нь тал төвлөсөн куб бүтэцтэй ба түүний эгэл торыг Дикартын координатын хүрээнд дараах байдлаар дүрслэв.


$$\vec{a}_1 = \frac{1}{2}a \begin{pmatrix} 0 \\ 1 \\ 1 \end{pmatrix} (1); \vec{a}_2 = \frac{1}{2}a \begin{pmatrix} 1 \\ 0 \\ 1 \end{pmatrix} (2); \vec{a}_3 = \frac{1}{2}a \begin{pmatrix} 1 \\ 1 \\ 0 \end{pmatrix}$$

Магнийн ферритийн нормаль шпинел үе дэх магни болон төмрийн атомуудын байрлал тетраэдр болон октаэдр суурьшилд сууна гэдгийг тус тус харуулав.

$$\vec{r}_{Mg_1} = \frac{1}{8}a \begin{pmatrix} 0 \\ 0 \\ 0 \end{pmatrix} (4); \vec{r}_{Mg_2} = \frac{1}{8}a \begin{pmatrix} 2 \\ 2 \\ 2 \end{pmatrix} = \frac{1}{8}(\vec{a}_1 + \vec{a}_2 + \vec{a}_3)$$

$$\vec{r}_{Fe_1} = \frac{1}{8}a \begin{pmatrix} 1 \\ 5 \\ 5 \end{pmatrix} = \frac{1}{8}(9\vec{a}_1 + \vec{a}_2 + \vec{a}_3) (6); \vec{r}_{Fe_2} = \frac{1}{8}a \begin{pmatrix} 5 \\ 1 \\ 5 \end{pmatrix} = \frac{1}{8}(\vec{a}_1 + 9\vec{a}_2 + \vec{a}_3)$$

$$\vec{r}_{Fe_3} = \frac{1}{8}a \begin{pmatrix} 5 \\ 5 \\ 1 \end{pmatrix} = \frac{1}{8}(\vec{a}_1 + \vec{a}_2 + 9\vec{a}_3) (8); \vec{r}_{Fe_4} = \frac{1}{8}a \begin{pmatrix} 5 \\ 5 \\ 5 \end{pmatrix} = \frac{5}{8}(\vec{a}_1 + \vec{a}_2 + \vec{a}_3)$$



Зураг 3.1. (А) диамонд (В) пирохлор дэд торууд.

Тооцоог хийхдээ Магнийн ферритын хувьд дараах хоёр тохиолдлыг авч үзэв.

$$1. (Mg_{1-\delta}Fe_{\delta})[Mg_{\delta}Fe_{2-\delta}]O_4$$

- $\delta = 0$  ( $Mg$ )<sup>Tet</sup>[ $Fe_2$ ]<sup>Oct</sup> $O_4 \rightarrow$  нормаль шпинел
- $\delta = 1$  ( $Fe$ )<sup>Tet</sup>[ $MgFe$ ]<sup>Oct</sup> $O_4 \rightarrow$  инверс шпинел бүтэцтэй тохиолдлууд дээр тооцоог тус тус хийв.

(А) болон (В) дэд торууд дахь соронзон ионууд нь тетраэдр ба октаэдр гэсэн кристалл оронд тус тус байрлана гэж үзэж дараах тооцооллуудыг гүйцэтгэв.

### 3.2. $MgFe_2O_4$ -ийн онолын тооцооны үр дүн

Бид квант механикийн аргыг ферросоронзон (FM) ба антиферросоронзон (AFM) төлөвүүд дээр куб  $MgFe_2O_4$  фазын хувьд спиний туйлшралыг тооцоолон дараах үр дүнг гарган авав.

Нормаль шпинел бүтэц бүхий  $(Mg)_A[Fe_2]_BO_4$  нэгдлийн соронзон шинж чанар нь пироклор дэд торон дахь төмрийн гурван валенттай ион болох  $Fe^{3+}$ -ээр тодорхойлогдоно. Соронзон ионуудын спин нь В дэд торын булангуудад суух бөгөөд соронзон ион нь тэнцүү тоогоор хуваагдан сууна. Тиймээс антиферросоронзон төлөвүүдийн мөхөлт нь  $AB_2O_4$  томьёо бүхий нормаль шпинел бүтцийг алдагдуулдаг байна.


Нормаль шпинел бүтэц бүхий  $(Mg)_A[Fe_2]_BO_4$ -ийн онолын тооцооны үр дүнгээс соронзон моментууд нь  $Fe^{3+}$  ионы спин дээш чиглэсэн үед  $M(Fe_1)=4,03 \frac{\mu_B}{\text{атом}}$ , харин  $Fe^{3+}$  ионы спин доош чиглэсэн үед  $M(Fe_2)=-4,35 \frac{\mu_B}{\text{атом}}$  тус тус гарав. Мөн инверс шпинел бүтэц бүхий  $(Fe)_A[MgFe]_BO_4$ -ийн үед  $Fe^{3+}$  ион нь цөөн тооны Mg-ийн соронзон ионтой холилдон суух ба инверс шпинелийн үндсэн төлөвийн энерги нь нормаль шпинел бүтэцтэй үеийнхээс  $179,12 \frac{\text{мэВ}}{\text{тор}}$ -оор нэмэгдэж байв.

Нормаль, хагас инверс, бүтэн инверс шпинел тохиолдлуудад FM, AFM/FIM төлөвүүд хоорондын энергийн зөрүү  $\Delta E$  –ийг тус бүр тооцоолов. Магнийн ферритын нормаль шпинел тохиолдолын үндсэн төлөв нь хагас болон бүтэн инверс үеийнхээс илүү гүн сууж байсан нь нормаль шпинель бүтэц илүү тогтвортойг илэрхийлж байна. Торын параметр ( $a$ ) болон соронзон шинж чанарын хувьд  $M(Fe_1)$ ,  $M(Fe_2)$  -ийн онолын тооцооны үр дүн туршлагын [28],[29],[30] ажлын үр дүнтэй илүү тохирч байв.

Харин бүтэн инверс шпинел төлөвийн төмрийн соронзон моментууд нь  $M(Fe_1) = 3,99 \frac{\mu_B}{\text{атом}}$ ,  $M(Fe_2) = -4,35 \frac{\mu_B}{\text{атом}}$  гарав. Эдгээр үр дүн нь нейтрон дифракцийн судалгааны үр дүнтэй тохирч байна. FM болон AFM/FIM төлөвүүд хоорондын энергийн зөрүү нь нормаль шпинел болон инверс шпинел


тохиолдолд тус тус  $\Delta E = 15,56 \frac{\text{мэВ}}{\text{тор}}$  болон  $\Delta E = 16,28 \frac{\text{мэВ}}{\text{тор}}$  байна.  $(\text{Fe})_A[\text{MgFe}]_B\text{O}_4$  үед AFM төлөв задарч спинүүдийн чиглэл хоорондын энергийн өөрчлөлт дээшээ чиглэлд  $0,512 \frac{\text{мэВ}}{\text{тор}}$  байна.

Мөн  $\text{MgFe}_2\text{O}_4$  нэгдлийн төлөвийн нягтыг нормаль шпинел тохиолдолд DFT болон DFT+U аргуудаар тооцоолсон үр дүнг (Зураг 3.2)-т үзүүлэв. Хар өнгөөр нийлбэр төлөвийн нягт, ногоон өнгөөр Хүчилтөрөгч  $\text{O}(2p)$ , бор өнгөөр Магний  $\text{Mg}(2p)$ , улаан өнгөөр Төмөр  $\text{Fe}_1(3d)$ , хөх өнгөөр Төмөр  $\text{Fe}_2(3d)$  ионуудыг тус бүр тэмдэглэв.



**Зураг 3.2.**  $(\text{Mg})_A[\text{Fe}_2]_B\text{O}_4$  нэгдлийн (a) DFT болон (b) DFT + U аргуудаар тооцоолсон нормаль шпинел үеийн нийлбэр болон орбиталь төлөвийн нягт. (Тэг энерги нь ферми түвшинг илэрхийлнэ.)

$(\text{Mg})_A[\text{Fe}_2]_B\text{O}_4$  –ийн нормаль болон инверс шпинел тохиолдлуудын хувьд төлөвийн нягтуудыг байгуулахад нормаль шпинел үед антиферросоронзон төлөвтэй байгаа нь (Зураг 3.3a)-аас харагдаж байна. Учир нь нормаль шпинел үед  $\text{Mg}^{(\text{tet})}(\text{Fe}^{2+}\text{Fe}^{3+})\text{O}_4$  буюу төмрийн хоёр өөр валент бүхий ионууд октаэдр байрлал дээрээ харилцан тэнцвэртэй сууж байгаа учир төлөвийн нягт симметр гарсан байна. Харин инверс шпинел тохиолдолд  $(\text{Fe}^{2+})^{(\text{tet})}(\text{MgFe}^{3+})^{\text{Oct}}\text{O}_4$  буюу төмрийн ион тетраэдр байрлалд сууж байгаа магнийн ион октаэдр байрлалд сууж байгаа төмрийн ионтой байрлалаа солино. Үүнээс шалтгаалан тетраэдр байрлалд сууж төмөр октаэдр байрлалд сууж байгаа төмөр тус бүрийн спин эсрэг чиглэлтэй болж улмаар (Зураг 3.3b)-д харуулснаар симметр бага зэрэг алдагдаж сул феррисоронзон эффект өгч байна.




**Зураг 3.3.**  $(Mg)_A[Fe_2]_B O_4$  нэгдлийн (a) нормаль болон (b) инверс шпинел үеийн DFT + U тооцооны нийл ба орбиталь төлөвийн нягт. (Тэг энерги нь ферми төвшинг илэрхийлнэ).

### 3.3. $Y_3Fe_5O_{12}$ , $Y_3Al_5O_{12}$ нэгдлүүдийн онолын судалгаа

$Y_3Fe_5O_{12}$  (YIG),  $Y_3Al_5O_{12}$  (YAG) нэгдлүүдийн электрон бүтцийн онолын судалгааг *Quantum espresso* багц программын тусламжтайгаар гүйцэтгэв. Кристалл бүтцийн хувьд энэхүү хоёр нэгдэл нь *la3d* огторгуйн групп, *m3m* цэгэн групп-д харьяалагддаг.

Куб бүтэц бүхий YIG нэгдлийн торын тогтмол нь 12.376 Å ба эгэл тор бүр нь 24 ширхэг  $Y^{3+}$ , 40 ширхэг  $Fe^{3+}$ , 96 ширхэг  $O^{2-}$  ионуудаас нийт 160 атомаас бүрдэнэ.  $Y^{3+}$  ион нь *c* хэсэгт байрлах ба 8 хүчилтөрөгчийн атомаар хүрээлүүлсэн 8 өнцөг 12 талтай олон талт, 40  $Fe^{3+}$  ионуудын 16 нь *a* буюу октаэдр хэсэгт, 24 нь *d* буюу тетраэдр хэсгүүд тус тус байрлана (Зураг 3.4).

YAG хувьд Y болон O атомууд нь эгэл торын тогтмол нь 12.004 Å, Y болон O атомуудын байрлалын хувьд YIG-ийн атомуудын байрлалтай адил, харин  $Al^{3+}$  ионуудын 16 нь *a* буюу октаэдр хэсэгт, 24 нь *d* буюу тетраэдр хэсгүүд тус тус байрлана.




**Зураг 3.4.** а –  $Y_3Al_5O_{12}$  нэгдлийн эгэл тор, б –  $Y_3Fe_5O_{12}$  эгэл торд байрлах *a*, *c*, *d* хэсгүүд.

Хатуу биеийн онолын судалгааны тооцоонд нягтын функционал онолыг өргөн ашигладаг бөгөөд тоохон бодох хими, тоохон бодох физикт хамгийн түгээмэл хэрэглэгддэг аргуудын нэг юм. Бид тооцоондоо хавтгай долгионы кинетик энергийг 90 Рб, бриллион зон дахь *k* цэгийн торыг  $3 \times 3 \times 3$  харьцаатай байхаар, цэнэгүүдийн түгэлтийг электроны суурьшил Гауссын түгэлтээр 0.02 Рб байхаар авлаа.

YIG нэгдлийн соронзон шинж нь *a* хэсгийн  $Fe^{3+}$  ион, *b* хэсгийн  $Fe^{3+}$  хоорондох харилцан үйлчлэлээс гарч ирдэг. Харин YAG нэгдлийн хувьд соронзон соронзон шинж чанар байхгүй. Иймд YIG нэгдлийн тооцоо гүйцэтгэхдээ спины конфигурацийг тооцсон бол YAG нэгдлийн тооцоог гүйцэтгэхдээ спин тооцоогүй гүйцэтгэсэн болно. Y, Fe, O атомуудын *p*, *d* орбиталиуд дахь электрон нь дамжуулалд оролцох боломжтой нь тооцооны үр дүнгээс харагдаж байв.  $Y_3Fe_5O_{12}$  нэгдлийн хувьд металл шинж чанартай харин  $Y_3Al_5O_{12}$  нэгдэл хагас дамжуулагч шинж чанартай байв.


Электрон бүтцийн тооцоог Математик тоон технологийн хүрээлэнгийн тооцооллын төвийн супер компьютерүүд ашиглан параллелиар тооцоолсон. Нягтын функциональ онол ашиглан YIG, YAG нэгдлүүдийн төлөвийн нягтыг тооцоолсон үр дүнг зураг 3.5-д үзүүлэв.



**Зураг 3.5.** *a* - YAG нэгдлийн төлөвийн нягт, *б* - YIG нэгдлийн спин дээшээ болон доошоо харсан тохиолдлуудад тооцсон төлөвийн нягт.

Атомуудын орбиталиас хамаарсан төлөвийн нягтын тооцооноос харахад Y, Fe, Al, O-ийн атомуудын *p*, *d* орбиталиуд дахь электрон нь цахилгаан дамжуулалд оролцох боломжтой нь харагдаж байв. YIG нэгдлийн хувьд металл шинж чанартай харин YAG нэгдэл хагас дамжуулагч шинж чанартай байв. DFT тооцооноос гарсан тэнцвэржилтэд орсон торын параметруудийн ашиглан температураас хамаарсан соронзон шинж чанарын тооцоог Монте-Карло аргын тусламжтайгаар гүйцэтгэв.

Төмрийн атом хоорондын харилцан үйлчлэлийг тооцон соронзон шинж чанарыг тооцоолохдоо хамгийн ойр хөрш орших төмрийн атомуудын харилцан үйлчлэлээр тооцоолсон (Зураг 3.6).



**Зураг 3.6.** Fe-Fe-ийн харилцан үйлчлэлийн схем. Шулуун шугамаар ойрын хөршийг, тасархай зураасаар 2 дахь ойрын хөршүүдийг илэрхийллээ. aa, dd, ad нь харгалзан  $Fe^O-Fe^O$  (октаэдр-октаэдр),  $Fe^T-Fe^T$  (тетраэдр-тетраэдр) болон  $Fe^O-Fe^T$  (октаэдр-тетраэдр) байрлалууд дахь харилцан үйлчлэлүүдийг тус тус илтгэнэ [31].


YIG системийн соронзон шинж чанар нь Гейзенбергийн загвараар маш сайн тайлбарлагддаг бөгөөд соронзон харилцан үйлчлэлийг дараах эффертив соронзон Гамилтонианаар тайлбарлан авч үзэж болно.

$$H = H_1^{ex} + H_2^{ex}$$

Энд

$$H_1^{ex} = \frac{1}{2} \sum_{\langle i,j \rangle_1} J_{1,ij} S_i \cdot S_j, \quad H_2^{ex} = \frac{1}{2} \sum_{\langle i,j \rangle_2} J_{2,ij} S_i \cdot S_j \quad (3.1)$$

Энд анхдагч болон хоёрдогч хамгийн ойр орших атомуудын соронзон харилцан үйлчлэлийг  $H_1^{ex}$ ,  $H_2^{ex}$  тэмдэглэгээгээр тус тус илэрхийлэв. Мөн энэхүү тооцоонд  $Fe^{+3}$  ионы спин квант тоог  $S=5/2$  үзсэн бөгөөд соронзон харилцан үйлчлэлийг илэрхийлж буй  $J$  параметруудийг *DFT* тооцооны үр дүнгээс “four state energy mapping method” аргыг ашиглан гаргаж авсан [32,33]. Тэгшитгэл (3.1)-ийг ашиглан Монте-Карло (Parallel Tempering Monte Carlo) аргаар [34] тооцоог  $4 \times 4 \times 4$  хэмжээтэй *supercell* дээр явуулж YIG системийн температураас хамаарсан соронзон шинж чанарыг гаргаж авав.



**Зураг 3.7.** 0-20 Тесла тогтмол соронзон оронд дахь YIG системийн температураас хамаарсан соронзон шинж чанар ба Кюри температурын хамаарал.

Монте-Карло тооцоог 2000 алхамтайгаар гүйцэтгэсэн бөгөөд 5.6 Å дотор нийтдээ 5 өөр соронзон харилцан үйлчлэл олсон ба эдгээрийн  $J$  параметруудийг хүснэгт 3.1-д үзүүлэв.

**Хүснэгт 3.1.**  $J$  параметрууд. (анхдагч болон хоёрдогч хамгийн ойр орших атомуудын үйлчлэлийг 1NN ба 2NN тэмдэглэгээгээр тус тус илэрхийлэв)

Соронзон харилцан үйлчлэл	$J$ (эВ)
1NN Fe <sup>T</sup> - Fe <sup>O</sup>	0.007448
1NN Fe <sup>T</sup> - Fe <sup>T</sup>	0.000364
1NN Fe <sup>O</sup> - Fe <sup>O</sup>	0.000084
1NN Fe <sup>O</sup> - Fe <sup>O</sup>	0.000040
2NN Fe <sup>T</sup> - Fe <sup>O</sup>	0.000156

Зураг 3.7-д YIG системийн соронзон шинж чанарыг 0-20 Тесла тогтмол соронзон оронд (DC magnetic field) Монте-Карло аргаар тооцоолсон үр дүнг үзүүлэв (Хүснэгт 3.1). Үр дүнгээс үзвэл, бидний тооцоогоор олсон YIG системийн соронзон шинж чанар, хувийн дулаан багтаамжийн утгууд нь туршилтын үр дүнтэй сайн тохирч байгаа нь харагдаж байна [35]. Тооцооны үр дүнгээс харахад тогтмол соронзон орон ихсэхэд Кюри температур дагаад шугаман хамаарлаар өсөж байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл тогтмол соронзон орон болон Кюри температур хоорондоо шууд шугаман хамааралтай болох нь ажиглагдлаа.

### 3.4. Дүгнэлт

$(Mg)_A[Fe_2]_BO_4$  нэгдлийн онолын тооцооны үр дүнгээс магни болон төмрийн атомуудын байрлал тетраэдр болон октаэдр байрлалд хэрхэн яаж суухаас түүний соронзон шинж чанар хүчтэй хамаарч байгааг харуулж туршилтын үр дүнг бататгалаа. Нормаль шпинел тохиолдолын үндсэн төлөв нь хагас болон бүтэн инверс үеийнхээс илүү гүн сууж байсан нь нормаль шпинель бүтэц илүү тогтвортойг илэрхийлж байв. Соронзон параметруудийн үр дүн нь нейтрон дифракцаар тодорхойлсон үр дүнгүүдтэй сайн тохирч байв.

$Y_3Fe_5O_{12}$  нэгдлийн онолын тооцооны хувьд түүний соронзон шинж чанар нь төмрийн атомуудаас хэрхэн хүчтэй хамаарч байгааг, төмөр-төмөрийн атомуудын харилцан үйлчлэлийг Монте-Карло аргын тусламжтайгаар тодорхойлов. Эдгээр параметруудийн тусламжтайгаар температураас хамаарсан тогмол соронзон орон дахь хувийн дулаан болон соронзон моментыг илүү нарийвчлал сайтайгаар тодорхойллоо.

## ДӨРӨВ. ФЕРРИТ НАНО МАТЕРИАЛЫН БҮТЭЦ, ШИНЖ ЧАНАРЫН СУДАЛГАА

### 4.1. Магнийн феррит нэгдлийн судалгаа

Магнийн феррит нь холимог шпинел бүтэцтэй бөгөөд  $Fe^{3+}$  ион болон  $Mg^{2+}$  ионууд нь тетраэдр болон октаэдр байрлалд тархан суурьшдаг.  $Mg^{2+}$  ионууд соронзон шинж чанаргүй боловч  $MgFe_2O_4$  нь соронзон шинж чанарыг харуулдаг нь тухайн материалын сонирхолтой шинж чанар юм. Түүний дулаан ялгаруулах шинж чанар нь гарган авах арга, бөөмийн хэмжээнээс хэрхэн хамаарч буйг тодорхойлох судалгааг гүйцэтгэсэн.


**Химийн синтезийн золь-гелийн арга:** Химийн синтезийн золь-гелийн аргаар  $MgFe_2O_4$  феррит материалыг гарган авахдаа магнийн нитрат (>99%), төмрийн нитрат (>99%), нимбэгний хүчил (>99.5%) – ийг тодорхой молийн харьцаагаар хольж соронзон хутгуур дээр 60-80°C температурт гель хэлбэрт оруулах хүртэл 6 цаг халааж 12 цагийн турш 100°C – т хатаав. Үүний дараа 1100°C – т 3 цаг шатааж дулааны боловсруулалтад оруулаад аяндаа хөргөж тасалгааны температурт хүргэх замаар гарган авлаа.

**Химийн синтезийн хатуу төлөвийн урвалын арга:**  $MgFe_2O_4$  нунтаг феррит нэгдлийг Японы Нийхама хотын Технологийн үндэсний хүрээлэнд хатуу төлөвийн урвалын аргаар тээрэмдэгч аппаратаар циркон бөмбөлөг ашиглан этанолын орчинд нано нунтаг ферритийн дээжийг гарган авсан [36].

#### 4.1.1. Кристалл бүтцийн судалгаа

Золь-гелийн арга болон хатуу төлөвийн урвалын аргаар гарган авсан  $MgFe_2O_4$  дээжүүдийн тасалгааны температурт хэмжсэн рентген дифракцын спектрийг зураг 4.1 –д үзүүлэв. Хэмжилтийн үр дүнг Ритвельдийн арга ашиглан боловсруулалт хийж бүтцийн параметруудийг тодорхойллоо (хүснэгт 4.1).

Рентген дифракцын спектрийн боловсруулалтаас үзэхэд  $MgFe_2O_4$  төрлийн куб шпинел (ICCD 00-088-1941), огторгуйн групп нь Fd-3m кристалл бүтэцтэй, ямар нэгэн хольц фаз илрээгүй цэвэршилт сайтай дээж болох нь харагдаж байна.




**Зураг 4.1.** а) Золь-гель аргаар болон б) Хатуу төлөвийн аргаар гарган авсан  $MgFe_2O_4$  дээжүүдийн рентген дифракцын спектр

Туршилтын үр дүнгээс дундаж кристаллитын хэмжээг Дебай-Шеррерийн тэгшитгэлийг ашиглан (311) хавтгайн хувьд дараах харьцаагаар тооцоолоход ~ 50 нм байна.

$$D = \frac{K\lambda}{\beta \cos\theta} \quad (4.1)$$

Энд:  $K$  - хэлбэрийн фактор (0.9),  $\lambda$  - долгионы урт,  $\beta$  - интеграл өргөн (FWHM).

Рентген дифракцын хэмжилтийн үр дүнг ашиглан золь-гел аргаар гарган авсан  $MgFe_2O_4$  нэгдлийн эгэл торын кристалл бүтцийг DIAMOND программаар байгуулсан.



**Зураг 4.2.**  $MgFe_2O_4$  нэгдлийн эгэл торын кристалл бүтэц


Зураг 4.2 –д үзүүлснээр  $MgFe_2O_4$ -нь эгэл торондоо 56 атомтай бөгөөд цэнхэр өнгөөр 8a тал буюу тетраэдр дэд орон тор дээр сууж байгаа магнийн атомуудыг, улаан өнгөөр 32e тал дээр сууж байгаа хүчилтөрөгчийн атомуудыг, шар өнгөөр 16d тал буюу октаэдр дэд орон тор дээр сууж байгаа төмрийн атомуудыг тус тус дүрслэв.

**Хүснэгт 4.1.**  $MgFe_2O_4$  бүтцийн параметрууд

Гарган авсан арга	Золь-гел	Хатуу төлөв
Торын тогтмол (Å)	8.382	8.374
Кристаллитын хэмжээ (нм)	58	54
Брэгг фактор (%)	2.88	2.03
Жинлэсэн фактор (%)	14.3	10.4

#### 4.1.2. Молекул бүтцийн судалгаа

Нил улаан туяаны спектрофотометр (FTIR) –н хэмжилтийг  $MgFe_2O_4$  нэгдлийг KBr-ын нунтагтай 1:10 массын харьцаатайгаар хольж  $400 - 4000\text{cm}^{-1}$  мужид хэмжилтийг хийв. Хэмжилтийн үр дүнгээс харахад  $400 - 1000\text{cm}^{-1}$  мужид металлын шингээлтийн хэлбэлзэл үүсдэг ба энэ мужид кристалл бүтэц дэх атомууд (металл – хүчилтөрөгч хоорондын ) -ын хоорондох зай өөрчлөгдсөнөөр үүсэх валентын хэлбэлзэл илэрсэн.



**Зураг 4.3.**  $MgFe_2O_4$  дээжийн нил улаан туяаны спектрометрийн хэмжилтийн үр дүн

Энэхүү валентын хэлбэлзлийг  $\nu$  үсгээр тэмдэглэдэг ба өндөр давтамжийн холбоо болох ( $\nu_1$ ) -  $580\text{cm}^{-1}$  мужид тетраэдр дэд орон тор дээрх  $\text{Mg}^{2+}$  исэлдэхүйн зэрэгтэй катионы хэлбэлзэл, харин бага давтамжийн холбоо болох ( $\nu_2$ ) -  $418\text{cm}^{-1}$  мужид октаэдр дэд орон тор дээрх  $\text{Fe}^{3+}$  исэлдэхүйн зэрэгтэй катионы хэлбэлзэл ажиглагдсан (зураг 4.3).

Шингээлтийн хэлбэлзлээс хамааруулж кристалл бүтэц дэх тетраэдр болон октаэдр дэд орон тор дээр суурьшиж байгаа металл – хүчилтөрөгч хоорондын холбоосын хүчийг дараах тэгшитгэлээр тооцоолж [37] үр дүнг хүснэгт 4.2 –т үзүүллээ.

$$f = 4\pi^2 c^2 \nu^2 \mu \quad (4.2)$$


Энд:  $c$ - гэрлийн хурд,  $\nu$ - долгион тоо  $\text{cm}^{-1}$ ,  $\mu$ - эмхтгэсэн масс =  $\frac{m_1+m_2}{m_1m_2}$ ,  $m_1$ - катионы масс,  $m_2$ -анионы масс.

**Хүснэгт 4.2.** Кристалл бүтэц дэх атомуудын хоорондох холбоос хүчний тооцооны үр дүн

Гарган авсан арга	Золь-гель	Хатуу төлөв
Тетраэдр дэх ионы шингээлт $\nu_1$ ( $\text{cm}^{-1}$ )	568.14	551.64
Октараэдр дэх ионы шингээлт $\nu_2$ ( $\text{cm}^{-1}$ )	406.98	402.41
Тетраэдр дэх холбоос хүч $f_T$ ( $\times 10^5$ дин/см)	2.36	2.22
Октараэдр дэх холбоос хүч $f_O$ ( $\times 10^5$ дин/см)	1.21	1.18

#### 4.1.3. Дулаан ялгаруулалтын хэмжилт

$\text{MgFe}_2\text{O}_4$  феррит дээжийн дулаан ялгаруулах процессыг хувьсах соронзон орон үүсгэдэг төхөөрөмжийн тусламжтайгаар судлав. Соронзон дээжүүдийг 50 мг хэмжээтэйгээр 1 мл нэрмэл усанд хийж дулаан ялгаруулалтын хэмжилтийг гүйцэтгэлээ. Зураг 4.4 –т дээж болон уснаас хамаарсан температурын өөрчлөлтийн утгуудыг харуулав.



**Зураг 4.4.**  $MgFe_2O_4$  нэгдлийн хувьсах соронзон орны нөлөөгөөр үүсэх температур, хугацааны хамаарал

Эндээс үзэхэд тодорхой хугацааны дараа (~17–20 мин) дээжүүдийн температур тогтворжиж, температурын хамгийн их буюу ханалтын утга нь золь-гель аргаар гарган авсан дээжийн хувьд 42°C хүрч байсан бол хатуу төлөвийн урвалын аргаар гарган авсан дээжний хувьд 33°C байв. Уг үр дүнгээр томьёо (1.10) –ийг ашиглан ХШЧ –ыг тодорхойлов. ХШЧ утгуудыг тооцоолоход золь-гел – 5.25 Вт/гр, хатуу төлөвийн арга – 3.15 Вт/гр гарсан.


## 4.2. Зэсийн феррит нэгдлийн судалгаа

Зэсийн феррит  $\text{CuFe}_2\text{O}_4$  – ийн хувьд хамгийн их анхаарал татдаг сул соронзон феррит материалын нэг юм. Зэсийн феррит нь урвуу шпинел бүтэцтэй бөгөөд  $\text{Cu}^{2+}$  катионууд октаэдр хэсэгт байрладаг.  $\text{CuFe}_2\text{O}_4$ -ийн нэг онцлог шинж чанар нь энэ нэгдэл нь I41/amd орон зайн бүлэгтэй тетрагональ шпинел бөгөөд  $380^\circ - 450^\circ$  температурт куб симметрэй болж хувирдаг байна.

**Химийн синтез:**  $\text{CuFe}_2\text{O}_4$  соронзон nano материалыг золь-гелийн аргаар синтезлэн авсан. Синтезийг явуулахдаа зэсийн нитрат  $\text{Cu}(\text{NO}_3)_2 \cdot 6\text{H}_2\text{O}$  (99.0%), төмрийн нитрат  $\text{Fe}(\text{NO}_3)_3 \cdot 9\text{H}_2\text{O}$  (>98.5%), нимбэгний хүчил  $\text{C}_6\text{H}_8\text{O}_7$  (>99,5%)–үүдийн молийн харьцааг 1:2:4 байхаар сонгон авч нэрмэл усанд уусгасны дараагаар аммоны гидроксид  $\text{NH}_4\text{OH}(\text{H}_3\text{NO})$  (>99,5%)-ийг уусмалын pH-ийг 7 болтол нэмж өгсөн. Гарган авсан уусмалыг  $60^\circ\text{C}$ -д 8 цагийн турш гель хэлбэртэй болтол нь соронзон хутгуураар холин ууршуулна. Үүссэн гелийг  $100^\circ\text{C}$ -д 12 цагийн турш хатаана. Үүний дараа  $900^\circ\text{C}$ ,  $1100^\circ\text{C}$  -д 3 цаг шатааж нунтаг дээжүүдийг гарган авсан ба тус бүрийг А, Б дээж гэж нэрлэв.

### 4.2.1. Кристалл бүтцийн судалгаа

Золь-гелийн аргаар гарган авсан  $\text{CuFe}_2\text{O}_4$  дээжийн тасалгааны температурт хэмжсэн рентген дифракцын спектрийг зураг 4.5-т үзүүлэв.



**Зураг 4.5.**  $\text{CuFe}_2\text{O}_4$  дээжийн рентген дифракцын үр дүн


Хэмжилтийн үр дүнг Ритвельдийн арга ашиглан боловсруулалт хийж, бүтцийн параметруудийг тодорхойллоо (4.3-р хүснэгт). Боловсруулалтын үр дүнд  $CuFe_2O_4$  дээж нь  $I4_1/amd$  огторгуйн групп бүхий тетрагональ бүтэцтэй байв. Нэмэлтээр  $CuO$  –ын (2.3 жин.%) фаз сарнилын өнцгийн  $2\theta = 38^\circ$  орчимд илэрсэн. Шатаалтын температур ихсэхэд рентген дифракцын пикийн өргөн нарийсаж байгаа нь дээж температур ихсэх тусам илүү кристаллжиж байгааг илэрхийлж байна. Кристаллитын хэмжээ  $1100^\circ C$  температурт 25.8 нм –ээс 31 нм болж өссөн ба эгэл торын эзлэхүүн тэлсэн байна. Дээжийн кристалл бүтцийг тодорхойлсон үр дүнг хүснэгт 4.3-т харуулав.

**Хүснэгт 4.3.** Зэсийн феррит дээжүүдийн рентген дифракцын үр дүн

Шатаалтын температур	Торын тогтмол (Å)	Хүчилтөрөгчийн координат	Атом хоорондын зай (Å)	Кристалл-жилтын хэмжээ (нм)	$R_{exp}$	$\chi^2$
1100°	5.8287(a)	y(O)	0.0142	1.91885 (A-O)	31.9	4.44
	8.6637(c)	z(O)	0.2559	2.3945 (B-O)		
900°	5.7976(a)	y(O)	0.0131	1.92476 (A-O)	25.8	4.58
	8.7243(c)	z(O)	0.2514	2.38016 (B-O)		


#### 4.2.2. Хувьсах соронзон оронд дулаан ялгаруулах туршилт

Соронзон материалын дулаан ялгаруулах үзэгдлийн концентрацаас хамаарсан хэмжилтийг А болон Б дээжийн хувьд усан орчинд, 50, 75, 100 мг/мл нөхцөлд явуулав. Температурын өсөлт болон концентрацийн хамаарлыг зураг 4.6-д үзүүллээ. Хэмжилтийн үр дүнгээс харахад 16 минутын дараа дээжүүдийн дулаан ялгаруулалт хамгийн их утгадаа ( $35.4^\circ C$ ) хүрч, тогтворжиж байлаа. Концентрац ихсэх тусам ялгаруулах дулааны хэмжээ ихсэж байна.



**Зураг 4.6.** Дээжүүдийн усан орчин дахь концентрацаас хамаарсан дулаан ялгаруулалтын хэмжилтийн (а) А дээж болон (б) Б дээжийн үр дүн

Мөн А болон Б дээжүүдийг физиологийн уусмал (7 рН) болон усан орчинд хэмжилтийг явуулж үр дүнг харьцуулан судаллаа (зураг 4.7).



**Зураг 4.7.** А, Б дээжүүдийн усан орчин болон физиологийн уусмал дахь концентрацаас хамаарсан дулаан ялгаруулалтын хэмжилтийн (а) 50 мг (б) 75 мг (в) 100 мг дээж, Энд ФУ-физиологийн уусмал

Физиологийн уусмал дахь А болон Б дээжүүдийн хувьд халалтын температур 32.5 болон 30.4 °С буюу усан орчноос илүү халж байв. Энэхүү хэмжилтийн үр дүнгээс бид орчин болон концентрацаас хамаарсан ХЧШ-н утгуудыг тэгшитгэл 1.10-ыг ашиглан А болон Б дээжийн хувьд тодорхойлсон хүснэгт 4.4-т үзүүлэв.

**Хүснэгт 4.4.** Температурын өөрчлөлт болон ЧХШ –ийн үр дүн

Дээж	Концентраци (мг)	ЧХШ (Вт/г)		Температур (°С)	
		Ус	ФУ	Ус	ФУ
А	50	1.61	1.6	31.5	32.3
	75	1.36	1.39	33.2	34.2
	100	1.22	1.26	35.4	36.5
Б	50	1.16	1.06	29.8	30.4
	75	0.96	0.98	31.3	32.2
	100	0.94	0.92	33.1	34.3

Уг орчноос хамаарсан дээжүүдийн дулаан ялгаруулалтын хэмжилтэд зөрүү ажиглагдсан ч чадлын хувийн шингээлтийн утгууд нь хоорондоо бараг ижил байсан нь дулаан ялгаруулалт нь орчны рН –аас илүүтэйгээр орчны дулаан багтаамжаас хамаарч буйг харуулж байна (Ус –  $c = 4.18$  Ж, Физиологийн уусмал -  $c = 4.06$  Ж).


### 4.3. Зэс-магнийн холимог $(Mg_{1-x}Cu_x)Fe_2O_4$ нэгдлийн судалгаа

Өмнөх судалгаанд феррит материалыг гарган авах химийн синтезийн горим тогтоох ажлыг гүйцэтгэсэн. Энэ хэсэгт магнийн ферритийн октаэдр байршилд орших А катионыг  $Cu^{2+}$  хольц элементээр  $(Mg_{1-x}Cu_x)Fe_2O_4$ ,  $x = 0.2, 0.4, 0.6, 0.8, 1.0$  хольцолж бүтэц, шинж чанарыг судалгааг гүйцэтгэсэн үр дүнг хэлэлцүүлнэ. Энэ хольц элемент нь ионы радиусын хувьд ойролцоо ( $r_{Mg} = 0.72 \text{ \AA}$ ,  $r_{Cu} = 0.73 \text{ \AA}$ ) учир кристалл торын гажиг үүсгэхгүй. Үүнээс гадна  $Cu^{2+}$  ион нь октаэдр байршилд суурьших илүү эрмэлзэлтэй байдаг (тогтвортой бүтцийн энерги бага) учир  $MgFe_2O_4$  кристаллын октаэдр байршил дахь  $Mg^{2+}$  ионыг халж суурьшина. Ингэснээр  $Mg^{2+}$  ( $\mu_B = 0$ ) соронзон бус элементийг соронзон шинж чанартай  $Cu^{2+}$  ( $\mu_B = 2$ ) ионоор хольцолсноор АВ харилцан үйлчлэлийн момент ихсэж соронзон шинж чанарыг нэмэгдүүлэх юм. Бүтцийн томьёо:  $(Mg_{1-\delta}Fe_{\delta})_A[Mg_{\delta-x}Cu_xFe_{2-\delta}]_B O_4$ ,  $x = 0.2, 0.4, 0.6, 0.8, 1.0$ .

**Химийн синтез:**  $Mg_{1-x}Cu_xFe_2O_4$ ,  $x = 0.2, 0.4, 0.6, 0.8, 1.0$  материалыг золь-гелийн аргаар синтезлэн гарган авч, бүтэц шинж чанарыг судлав. Магни нитрат  $Mg(NO_3)_2 \cdot 6H_2O$  (>99.0%), зэсийн нитрат  $Cu(NO_3)_2 \cdot 6H_2O$  (99.0%), төмрийн нитрат  $Fe(NO_3)_3 \cdot 9H_2O$  (>98.5%), нимбэгний хүчил  $C_6H_8O_7$  (>99,5%) –үүдийн молийн харьцааг 1:2:6 байхаар сонгон авч нэрмэл усанд уусгасны дараагаар аммоны гидроксид  $NH_4OH(N_3NO)$  (>99,5%)-ийг уусмалын рН-ийг 7 болтол нэмж өгсөн. Гарган авсан уусмалыг  $60^\circ C$ -д 8 цагийн турш гель хэлбэртэй болтол нь соронзон хутгуураар холин ууршуулна. Үүссэн гелийг  $100^\circ C$ -д 12 цагийн турш хатаана. Үүний дараа харгалзан  $500^\circ C$ ,  $700^\circ C$ ,  $900^\circ C$ ,  $1100^\circ C$  -д 3 цаг шатааж нунтаг дээжүүдийг гарган авсан.


#### 4.3.1. Кристалл бүтцийн судалгаа

Феррит төрлийн шпинел бүтэцтэй кристалл  $Mg_{1-x}Cu_xFe_2O_4$  ( $x = 0, 0.2, 0.4, 0.6, 0.8, 1$ ) нэгдлийн рентген дифракцын хэмжилтийн үр дүнг (Зураг 4.8)-д үзүүлэв. Рентген дифракцын аргаар бүрэлдэхүүнийг тодорхойлоход зэсийн хольцын хэмжээ  $x = 0, 0.2, 0.4, 0.6$  утгатай байхад куб бүтэцтэй шпинел фаз үүсэж байсан бол  $x = 0.8, 1.0$  утгатай болсон үед дифракцын пик ( $2\theta = 41.3^\circ$ ) хуваагдаж байгаа нь шинэ төрлийн тетрагонал  $CuFe_2O_4$  фаз үүсэж байгааг харуулж байна.



**Зураг 4.8.**  $Mg_{1-x}Cu_xFe_2O_4$  нэгдлийн рентген дифракцын хэмжилтийн үр дүн

Уг феррит материалууд нь эгэл үүрэндээ 56 атомтай бөгөөд зураг 4.9-д рентген дифракцын хэмжилтийн үр дүнг ашиглан  $MgFe_2O_4$  болон  $CuFe_2O_4$  нэгдлийн эгэл торын кристалл бүтцийг VESTA программаар байгуулж үзүүлээ. Хөх өнгөөр 8a тал буюу тетраэдр дэд орон тор дээр сууж буй атомуудыг, ногоон өнгөөр 32e тал дээр сууж байгаа хүчилтөрөгчийн атомуудыг, бор өнгөөр 16d тал буюу октаэдр дэд орон тор дээр сууж байгаа атомуудыг тус тус дүрслэв.



**Зураг 4.9.** а)  $MgFe_2O_4$ -ийн кристалл бүтэц, б)  $CuFe_2O_4$ -ийн кристалл бүтэц  
 $Mg_{1-x}Cu_xFe_2O_4$  нэгдлийн рентген дифракцын үр дүнгээс  $Cu^{2+}$  хольцын хэмжээ байгааг тодорхойлсон.  $Mg^{2+}$  катионы ионы радиус нь (тетраэдрт 0.57 Å ба


октаэдрт 0.72 Å) хольц  $Cu^{2+}$  катионы ионы радиустай (тетраэдрт 0.57Å ба октаэдрт 0.73 Å) ойролцоо учир торын параметрт бага хэмжээгээр ихэссэн нь ба уг рентген дифракцын үр дүнг хүснэгт 4.5 –д харуулав.

**Хүснэгт 4.5.**  $Mg_{1-x}Cu_xFe_2O_4$  нэгдлийн рентген дифракцын үр дүн

Дээж	Торын диаметр (Å)		Хүчилтөрөгчийн координат		Атом хоорондын зай (Å)	$R_{exp}$
	куб	тетрагональ	y(O)	z(O)		
$MgFe_2O_4$	8.375613	-	0.25643		1.8969 A-O 2.0477 B-O	4.67
$(Mg_{0.8}Cu_{0.2})Fe_2O_4$	8.379821	-	0.25578		1.8991 A-O 2.0473 B-O	5.88
$(Mg_{0.6}Cu_{0.4})Fe_2O_4$	8.385837	-	0.25712		1.9133 A-O 2.0403 B-O	4.15
$(Mg_{0.4}Cu_{0.6})Fe_2O_4$	8.377947	-	0.25398		1.9013 A-O 2.0467 B-O	4.58
$(Mg_{0.2}Cu_{0.8})Fe_2O_4$	8.3819	5.8793(a) 8.5131(c)	0.2568		1.9135 A-O 2.0401 B-O	3.95
$CuFe_2O_4$	-	5.8287(a) 8.6637(c)	y(O) 0.0142 z(O) 0.2559			4.44

#### 4.3.2. Молекул бүтцийн судалгаа


$Mg_{1-x}Cu_xFe_2O_4$  ( $x= 0, 0.2, 0.4, 0.6, 0.8, 1$ ) нэгдлийн нил улаан туяаны спектрофотометрийн хэмжилтийг KBr-ын нунтагтай 1:10 массын харьцаатайгаар хольж  $400cm^{-1} - 4000cm^{-1}$  хэмжилтийг хийв (Зураг 4.10). Энгийн шпинелийн эгэл торын хэлбэлзэл нь тетраэдр (A) болон октаэдр (B) дэд орон тор дээрх металл хүчилтөрөгч хоорондын валентын хэлбэлзлээс хамаардаг ба  $400-600 cm^{-1}$  мужид нормаль шпинел төрлийн бүтэц үүсэж байгаа бөгөөд энэхүү мужид хоёр гол холбоос үүсдэг [38]. Үүнд шингээгдэх өндөр давтамжийн холбоо ( $\nu_1$ )  $\sim 580cm^{-1}$  мужид тетраэдр дэд орон тор дээрх 2+ исэлдэхүйн зэрэгтэй катионы хэлбэлзэл харин бага давтамжийн холбоо ( $\nu_2$ )  $\sim 418cm^{-1}$  мужид октаэдр дэд орон тор дээрх 3+ исэлдэхүйн зэрэгтэй катионы хэлбэлзэл бий болсон.



**Зураг 4.10.**  $Mg_{1-x}Cu_xFe_2O_4$  нэгдлийн нил улаан туяаны хэмжилтийн үр дүн

Нил улаан туяаны хэмжилтээр металлын ионы валентын хэлбэлзэл нь долгион тооны их мужруу шилжиж байна (Зураг 4.11а). Энэ нь тетраэдр болон октаэдр торуудад суурьшиж байгаа анион болон катионы хоорондох зай зэсийн хольцын хэмжээнээс хамаарч өөрчлөгдсөнтэй холбоотой ба тэдгээр анион катионуудын хоорондох холбоос хүч өөрчлөгдсөнтэй холбоотой юм.

Тетраэдр болон октаэдр дэх анион катион хоорондын холбоосын хүч нь металлын валентын хэлбэлзлээс шугаман хамааралтай багасаж байна (Зураг 4.11б).




**Зураг 4.11.** а) Тетраэдр болон Октаэдр тор дахь шингээлт, б) Тетраэдр болон Октаэдр тор дахь холбоос хүч

**Хүснэгт 4.6.**  $Mg_{1-x}Cu_xFe_2O_4$  нэгдлийн тетраэдр болон октаэдр дэх ионы шингээлт болон тетраэдр болон октаэдр дэх ионы холбоос хүчний тооцооны үр дүн.

$x$	Тетраэдр дэх ионы шингээлт $\nu_1$ ( $cm^{-1}$ )	Октараэдр дэх ионы шингээлт $\nu_2$ ( $cm^{-1}$ )	Тетраэдр дэх холбоос хүч $f_T$ ( $\times 10^5$ дин/см)	Октараэдр дэх холбоос хүч $f_O$ ( $\times 10^5$ дин/см)
1	418.55	580.27	6.216	11.959
0.8	416.62	572.57	6.159	11.620
0.6	412.76	567.07	6.045	11.410
0.4	410.83	559.35	5.989	11.101
0.2	405.05	557.42	5.821	11.025
0	402.41	551.64	5.734	10.797

### 4.3.3. Дулаан ялгаруулалтын судалгаа

Зэс-магнийгын хольцоос хамаарсан 3 өөр дээжийн дулаан ялгаруулах процессыг усан орчинд судлав. Дулааны хэмжилтийг 2 мл усанд 50 мг дээж аван хувьсах соронзон орон үүсгэх төхөөрөмжөөр судалсан. Дээжүүдийн хувьд температур ханалтын утгадаа 17-20 минутад хүрч байв. Температур ханалтын утгууд  $x=0$ ,  $x=0.6$ ,  $x=1$  дээжүүдийн хувьд харгалзан  $40^\circ C$ ,  $42.4^\circ C$ ,  $30.8^\circ C$  байсан (зураг 4.12).



**Зураг 4.12.** Зэсийн ялгаатай агууламж бүхий дээжүүд а – температурын хугацаанаас хамаарсан өөрчлөлт, б – зэсийн агууламжаас хамаарсан халалт.

Дулааны эмчилгээний үед хавдрын эсийг устгахын тулд температурыг  $42^\circ C$  –т 30 минутын барих шаардлагатай байдаг бөгөөд мөн эрүүл эсэд нөлөөлөхгүйн

тулд  $46^{\circ}\text{C}$ -аас хэтэрч болохгүй. Манай судалсан дээжүүдийн хувьд  $x=0.6$  буюу  $(\text{Mg}_{0.4}\text{Cu}_{0.6})\text{Fe}_2\text{O}_4$  дээж хамгийн их дулаан ялгаруулж байсан бөгөөд хавдрын эсийг устгах температуртай ойролцоо дулаан ялгаруулсан. Үүнийг үйлчилж буй соронзон орны хүчлэгийг удирдан багасгах замаар бууруулах боломжтой.

Судалгаанд ашигласан дээжүүд болох  $x=0$ ,  $x=0.6$ ,  $x=1$  дээжүүдийн хувьд ХШЧ-г (4.3) томъёогоор тооцоолж үзэхэд харгалзан 9.6 Вт/гр, 11 Вт/гр, 5.5 Вт/гр гарсан.


#### 4.4. Хөнгөн цагаан-төмрийн $Mg(Al_xFe_{2-x})O_4$ нэгдлийн судалгаа

Өмнөх судалгаанд магнийн ферритийн А катионыг хольцолсон бол энэхүү хэсэгт В катионыг соронзон бус элементээр хольцолж бүтэц болон дулаан ялгаруулах шинж чанарт нөлөөлөх нөлөөллийг судалсан юм. Хольц элементээр  $Al^{3+}$  ионыг сонгон авсан нь ионы радиус ойролцоо ( $r_{Fe} = 0.55 \text{ \AA}$ ,  $r_{Al} = 0.535 \text{ \AA}$ ), соронзон шинж чанаргүй, нөгөө талаар  $MgAl_2Fe_4$  нь энгийн шпинел буюу  $Al^{3+}$  ион нь октаэдр байршилд суурьших эрмэлзэлтэй буюу холимог шпинелээс ялгаатай бүтэцтэй юм. Бүтцийн томьёо нь  $(Mg_{1-\delta}Fe_{\delta})_A[Mg_{\delta}Al_xFe_{2-\delta-x}]_BO_2$ ,  $x = 0.2, 0.4, 0.6, 0.8, 1.0$ .

**Химийн синтез:**  $MgAl_xFe_{2-x}O_4$  ( $x=0.0, 0.2, 0.3, 0.7, 2$ ) нунтаг холимог феррит нэгдлийг золь-гель аргыг ашиглан бэлтгэв. 100 мл нэрмэл усанд  $Mg(NO_3)_2 \cdot 6H_2O$ ,  $Al(NO_3)_3 \cdot 9H_2O$ ,  $Fe(NO_3)_3 \cdot 9H_2O$  нэгдлүүдийг тодорхой стехеометрийн харьцаатайгаар уусгаж нимбэгний хүчил болон этиленгликолтой тодорхой молийн харьцаатайгаар хольж  $200^\circ C$ -т гурван цаг халааж гель хэлбэртэй болгосон. Ферритийн анхдагч бүтцийг бий болгохын тулд гарган авсан гель хэлбэртэй дээжийг  $400^\circ C$  температурт нэг цаг шатаан органик нэгдлүүдийг зайлуулж агаартай орчинд  $400^\circ C$ - $1200^\circ C$  мужид нэг цаг шатааж нунтаг дээжүүдийг гарган авав.


##### 4.4.1. Кристалл бүтцийн судалгаа

Рентген дифракцын хэмжилтийг дифракцын өнцөг  $20$ - $80^\circ$ , хоолойн хүчдэл  $40$  кВ, гүйдэл  $20$  мА, Cu K $\alpha$  цацраг ашиглан тасалгааны температурт хийж гүйцэтгэв. Хэмжилтийн үр дүнг Ритвельдийн арга ашиглан боловсруулалт хийж бүтцийн параметруудийг тодорхойллоо (хүснэгт 4.7).



**Зураг 4.13.**  $MgAl_xFe_{2-x}O_4$  нэгдлийн рентген дифракцын хэмжилтийн үр дүн

Рентген дифракцын хэмжилтээс кристаллын ионы түгэлтээс хамаарч пикийн эрчмийн багасалт болон пикийн шилжилт ажиглагдаж байна. Энэ нь кристаллын эгэл торын хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой юм (зураг 4.13).




**Зураг 4.14.**  $MgAl_xFe_{2-x}O_4$  ( $x=0, 0.2, 0.3, 0.7$ ) нэгдлүүдийн Ритвельд аргаар боловсруулсан спектрүүд.

**Хүснэгт 4.7.**  $MgAl_xFe_{2-x}O_4$  ( $x=0, 0.2, 0.3, 0.7, 2$ ) нэгдлийн рентген дифрактограммыг Ритвельдийн аргаар боловсруулсны дараах кристалл бүтцийн параметрууд

x	$A_{\text{куб}}, \text{Å}$	Катионы түгэлт	
		Тетраэдр (8a) тор	Октаэдр (16d) тор
0.0	8.3849±0.0012	(Fe <sub>0.81</sub> Mg <sub>0.19</sub> ) <sub>A</sub>	(Fe <sub>1.19</sub> Mg <sub>0.81</sub> ) <sub>B</sub>
0.2	8.3529±0.0032	(Fe <sub>0.81</sub> Mg <sub>0.19</sub> ) <sub>A</sub>	(Fe <sub>1.10</sub> Mg <sub>0.76</sub> Al <sub>0.13</sub> ) <sub>B</sub>
0.3	8.3429±0.0018	(Fe <sub>0.81</sub> Mg <sub>0.19</sub> ) <sub>A</sub>	(Fe <sub>0.96</sub> Mg <sub>0.81</sub> Al <sub>0.21</sub> ) <sub>B</sub>
0.7	8.2913±0.0003	(Fe <sub>0.72</sub> Mg <sub>0.28</sub> ) <sub>A</sub>	(Fe <sub>0.47</sub> Mg <sub>0.78</sub> Al <sub>0.78</sub> ) <sub>B</sub>


Рентген дифрактограммыг Ритвельдийн аргаар боловсруулсан үр дүнгээс харахад торын параметр буурч кристаллын эгэл торын эзлэхүүн багасаж байна. тодорхойлсон  $MgAl_xFe_{2-x}O_4$  нунтаг ферритийн торын параметрийн утгыг нэгдлийн стехеометрийн харьцаа (x)-ээс хамааруулсан үр дүнг (Зураг 4.15) -д үзүүлэв. Хөнгөн цагааны тетраэдр дэд орон тор дээрх катионы түгэлтийн концентрацийн хэмжээнээс хамаарч торын параметрийн хэмжээ нь буурч байна ( $r_{\text{Al}} = 0.535\text{Å}$ ) <  $r_{\text{Fe}} = 0.55\text{Å}$ ).



**Зураг 4.15.**  $MgAl_xFe_{2-x}O_4$  кристаллын торын параметр

#### 4.4.2. Дулаан ялгаруулалтын судалгаа

$Mg(Al_xFe_{2-x})O_4$  феррит дээжийн дулаан ялгаруулах процессыг хувьсах соронзон орон үүсгэдэг төхөөрөмжийн тусламжтайгаар судлав. Соронзон дээжүүдийг 50 мг хэмжээтэйгээр 1 мл нэрмэл усанд хийж дулаан ялгаруулалтын хэмжилтийг гүйцэтгэлээ.



**Зураг 4.16.**  $Mg(Al_xFe_{2-x})O_4$  дээжүүдийн ялгаруулах дулаан болон ХШЧ хөнгөн цагааны концентрацийн хэмжээнээс хамаарсан хамаарал

Зураг 4.16 –д хольц элементийн концентрациас хамаарсан температурын өөрчлөлтийн утгуудыг харуулав. Эндээс үзэхэд тодорхой хугацааны дараа (~17–20 мин) дээжүүдийн температур тогтворжиж, температурын хамгийн их буюу ханалтын утга нь золь-гель аргаар гарган авсан дээжийн хувьд  $42^\circ\text{C}$  хүрч байсан бол хатуу төлөвийн урвалын аргаар гарган авсан дээжний хувьд  $33^\circ\text{C}$  байв. Мөн туршилтын үр дүнгээс томьёо (4.1) –ыг ашиглан ХШЧ –г тодорхойлсон.

ХШЧ –ын утгуудыг тооцоолоход  $MgFe_2O_4$  дээжийн хувьд – 5.25 Вт/гр, хөнгөн цагаанаар хольцолсноор концентрацаас хамаарч – 3.70 Вт/гр, 3.01 Вт/гр, 0.71 Вт/гр гарсан бөгөөд энэ нь хөнгөн цагааны хольцоос хамаарч соронзон шинж чанар буурсантай холбоотой юм.

**Хүснэгт 4.8.**  $MgAl_xFe_{2-x}O_4$  ( $x= 0, 0.2, 0.3, 0.7, 2$ ) нэгдлийн хувийн шингээх чадлыг тооцоолсон үр дүн

Дээж	ХШЧ (Вт/гр)
$MgFe_2O_4$	5.25
$MgAl_{0.2}Fe_{1.8}O_4$	3.70
$MgAl_{0.3}Fe_{1.7}O_4$	3.01
$MgAl_{0.7}Fe_{1.3}O_4$	0.71

#### 4.5. Дүгнэлт

Судалгааны ажлын хүрээнд химийн синтезийн горим тогтоохоор цэвэр  $MgFe_2O_4$ ,  $CuFe_2O_4$  нэгдлүүдийг хамгийн түгээмэл хэрэглэгддэг (гарц их, цэвэршилт өндөр г.м) химийн синтезийн золь-гел болон хатуу төлөвийн урвалын хоёр аргыг ашиглан гарган авав. Ингэхэд золь-гелийн аргаар гарган авсан  $MgFe_2O_4$  дээж нь куб шпинел бүтэцтэй, ямар нэгэн хольц байхгүй цэвэршилт өндөртэй, кристаллитын хэмжээ тохиромжтой (~50нм), дулаан дулаан ялгаруулах чадамж өндөр (42°) байв.

Хольц элемент ашиглан соронзон шинж чанарыг нь өөрчилж, удирдах зорилгоор  $MgFe_2O_4$  нэгдлийг  $Cu^{2+}$  элементээр хольцолж, бүтэц шинж чанарын хамаарлыг тодорхойлов. Зэсийн хольцын хэмжээ  $x=0.8$  хүрэх үед тетрагональ  $CuFe_2O_4$  фаз үүсэж байгааг тогтоолоо. Энэ нь тетраэдр дэх төмрийн агууламж хангалттай хэмжээнд хүрэх үед (манай тохиолдолд  $Cu$  агуулга 0.8 хүрэх) куб бүтцээс тетрагональ руу фазын шилжилт хийдэг болохыг үзүүлж байна. Кристалл бүтцийн нарийвчилсан судалгаагаар  $Cu^{2+}$  хольцын улмаас ферритийн эгэл торын эзлэхүүн бага хэмжээгээр тэлснээр холбоосын хүч буурсан, соронзон момент нь октаэдр дэд бүтцээс тетраэдр бүтэц рүү шилжсэн буюу торын хүчиллэгийн хэмжээ ихэссэн, тетраэдрийн байршил дээр төмрийн ионууд цугларснаар урвуу шпинел бүтэц үүссэн болохыг тодорхойлов. Дулаан ялгаруулах чадамжийг хэмжихэд  $x=0.6$  дээжийн хувьд хамгийн өндөр дулаан ялгаруулалт болох 42.6°C хүрсэн бөгөөд ХШЧ –г тодорхойлоход 11 Вт/гр буюу цэвэр магнийн феррит дээжээс (9.6 Вт/гр) өндөр байсан.

Мөн химийн синтезийн золь-гелийн арга ашиглан гарган авсан  $MgAl_xFe_{2-x}O_4$  нэгдлийн судалгааг хийлээ. Энд  $x$  –ийн утгыг 0, 0.2, 0.3, 0.7 –оор авсан бөгөөд рентген дифракцын аргаар бүтцийн параметрууд болон катионы түгэлтийг тодорхойлсон. Хөнгөн цагаан хольцын хэмжээ ихэсэх үед торын тогтмол 8.38 Å –аас 8.28 Å хүртэл буурсан бөгөөд хөнгөн цагааны атомын хувьд октаэдр байрлалд суурьшиж байсан. Уг дээжүүдийн дулаан ялгаруулах чадамжийг тодорхойлоход хөнгөн цагааны хольц нэмэгдэхэд ялгаруулах дулаан буурч байсан бөгөөд  $x$  –ийн утга 0.7 байхад маш бага буюу 26°C хүрч, ХШЧ нь 0.71 Вт/гр хүртэл буурсан.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд 71 кГц –н давтамж бүхий соронзон орон үүсгэх төхөөрөмжийг угсран дулаан ялгаруулах чадамжийн судалгааг гүйцэтгэсэн. Хэмжилтийг 50, 75, 100мг –аар сонгон авч дулаан ялгаруулалт дээжийн хэмжээнээс хэрхэн хамаархыг судлахад дээжийн концентрацийг өөрчилснөөр ялгаруулах дулааныг удирдах боломжтой бөгөөд ялгарах дулаан дээжийн концентрацаас пропорционал хамааралтай болохыг тогтоов. Мөн хэмжилтийг орчноос хамааруулах судлах зорилгоор ус болон физиологийн уусмалд хийн харьцуулахад хоорондох зөрүү нь орчны дулаан багтаамжаас хамаарч байв.

## ТАВ. ФЕРРИТ НАНО МАТЕРИАЛЫН ХЭРЭГЛЭЭ

Сүүлийн жилүүдэд хавдрын эсрэг халуун эмчилгээнд зориулж хувьсах соронзон орны нөлөөгөөр дулаан ялгаруулах чадамж өндөр материалыг судлах ажил эрчимтэй явагдаж байна [39]. Энэ аргын нэг болох гипертерм эмчилгээ нь хорт хавдрын эсийн орчны температурыг дээшлүүлж устгах зорилготой юм. Хорт хавдрын эсүүд нь эрүүл эстэй харьцуулахад бүтэц, морфологи, үйл ажиллагааны хувьд маш их өөрчлөлтөд орсон байдаг. Үүний нэг жишээ нь: халуунд мэдрэмтгий буюу тэсвэр муутай байх шинж чанар юм. Тиймээс гипертерм эмчилгээ нь мэс засал, хими эмчилгээ, цацрагийн эмчилгээтэй харьцуулахад гаж нөлөө багатай, бие махбодод эрсдэл багатай гэсэн давуу талтай [40].

### 5.1. Хорт хавдрын өнөөгийн тоо баримт

Дэлхийн хэмжээнд хорт хавдрын улмаас нас барж буй хүмүүсийн тоо жил бүр ихэссээр байна. 2019 оны тоо баримтаар нас барагсдын 6 хүн тутмын нэг хорт хавдрын улмаас хорвоог орхисноос эдгээрийн 70 гаруй хувь нь буурай болон дундаж хөгжилтэй орнуудын иргэд байна. 1990 онд хавдрын улмаас нас барсан хүний тоо 5.7 сая байсан бол 2021 онд 10 сая болж ихэссэн байна [41, 42].

Монгол орны хувьд жилд дунджаар 5000 гаруй хүн хорт хавдраар өвдөж, 3000 гаруй хүн нас барж байгаа ба нийт хавдартай гэж оношлогдсон өвчтөний 70 гаруй хувь нь хожуу үедээ эмнэлэгт хандсан гэсэн харамсалтай тоо мэдээ байна. Монгол улс нь ходоод болон элэгний хорт хавдраар өвчлөгсдийн тоогоороо дэлхийд тэргүүлж байгаа бол улаан хоолойн хавдраар 5-р байранд байна. Иймд хорт хавдрыг өвчлөлийн эрт үед нь оношлох, эмчлэх боломжийг нэмэгдүүлэх, боломжит шинэ арга, технологи хөгжүүлэх, нэвтрүүлэх шаардлага чухлаар тавигдаж байна.


Хорт хавдар нь хүн төрөлхтний хувьд шинэ өвчин биш, эрт үед ч хорт хавдар өвчин байсаар байжээ. Энгийн ойлголтоор бол хорт хавдар нь хүний биеийн аль нэг хэсэгт хэвийн эсийн оронд үүссэн гаж эсүүд зүй тогтолгүй өсч, олшрох процесс юм. Хавдрын эс нь цус болон лимф буюу тунгалгийн урсгалаар дамжин биеийн бусад хэсгүүдэд тархдаг ба энэ өвчин нь мутацид орсон генээс болж үүсдэгийг өнөөгийн шинжлэх ухаан нотлоод байна. Гаднын маш олон хүчин зүйлийн нөлөөгөөр ген мутацид орох ба уг генийг агуулсан эс хорт хавдрын эс болон хувирч маш хурдтай өсч улмаар организмын тэнцвэрт байдал алдагдана. Хорт хавдрын эсийг буй болгодог гол ген нь онкогенесис (Oncogenesis) ген юм.

Уг ген мутацид орж өөрчлөгдөн эсийг маш олноор нь хувилан олшруулж хавдрын хэмжээнд хүргэнэ. Эсрэгээрээ энэхүү хяналтгүй эсийн хуваагдлыг хавдар дарангуйлагч (Tumor suppressor genes) ген зогсоож засварладаг. Гэхдээ энэхүү хавдар дарангуйлагч ген мутацид орох магадлалтай. Энэ тохиолдолд хяналтгүй өсч буй эсийг зогсоох, засварлах боломжгүй болдог. Хавдар дарангуйлагч ген онкогенесис гентэй харьцуулбал мутацид орох магадлал бага байдаг.

Нийт хавдрын 90-95% нь хүрээлэн буй орчин, хувь хүний амьдралын хэв маяг, хооллолт зэргээс шалтгаалсан генийн гажгаас үүсдэг бол үлдсэн 5-10% нь удамшсан генээс болно. Хорт хавдар үүсгэхэд тамхи 25-30%, буруу хооллолт ба таргалалт 30-35%, халдварт өвчин 15-20%, цацраг, стресс болон хөдөлгөөний дутагдлаас 10% хүртэлх хувиар нөлөөлдөг байна.

## 5.2. Хорт хавдрын эмчилгээний аргууд

Хүн төрөлхтөн хорт хавдартай анх нүүр тулж, танин мэдэж, эмчлэхийг оролдох болсноос өнөөг хүртэл маш олон төрлийн эмчилгээний аргууд үүсэн бий болж хөгжсөөр байна. Тухайн өвчтөний биеийн байдал, хавдрын төрөл болон үе шатуудаас хамаарч тохирох хавдрыг устгах, багасгах, өсөлтийг удаашруулах, өвчтөний биеийг тогтворжуулах эмчилгээнүүдээс сонгодог байна. Ингэхдээ ихэвчлэн өвчтөнд үзүүлэх сөрөг нөлөөг багасгаж хэрэглэж буй аргын үр ашгийг нэмэгдүүлэхийн тулд хэд хэдэн аргийг хослуулан хэрэглэдэг. Өнөөг хүртэл хөгжүүлж байгаа эмчилгээний арга, технологиуд өвчтөнд үзүүлэх сөрөг нөлөөг арилгаж зөвхөн хавдартай хэсэгт үйлчлэл үзүүлэхийг үндсэн зорилго болгон ажиллаж байна. Хавдрын эмчилгээг дотор нь мэс засал, хими эмчилгээ, цацрагийн эмчилгээ, халуун эмчилгээ гэх зэргээр хуваана. (Зураг 5.1 )



Зураг 5.1. Хавдрын эмчилгээний төрлүүд

**Мэс засал:** Онолын хувьд цусны (гематологи) хавдраас бусад бүх хавдрыг мэс заслын эмчлэх боломжтой гэж үздэг байсан боловч амьдралд биелэгддэггүй. Хавдар хэдий жижиг хэмжээтэй байсан ч тодорхой нөхцөлд хүний биеийн бусад хэсэгт тархдаг. Мэс засал бүрэн хийх эрсдэлтэй, бусад хэсэгт тархсан байх магадлал өндөр байх зэрэг тохиолдолд химийн эмчилгээг давхар ашигладаг.

**Химийн эмчилгээ:** Химийн эмчилгээ нь хавдрын эсийг устгах зорилготой эмчилгээ юм. Хавдрын төрөл болон онцлогоос хамаарч 100 гаруй төрлийн хавдрын эсийг дарангуйлах эм, бэлдмэлийг эмчилгээнд хэрэглэж байна. Гэхдээ химийн эмчилгээ нь зөвхөн хавдрын эсийг устгах төдийгүй хүний биеийн хурдан хуваагдаж өсдөг эрүүл эсүүдэд сөрөг нөлөө үзүүлэх, устгах сөрөг талтай.

**Цацраг туяаны эмчилгээ:** Цацраг туяа эмчилгээ нь ионжуулагч цацрагийн тусламжтайгаар хорт хавдрыг эмчлэх арга юм. Цацрагийн эмчилгээг анагаах ухаан, эмчилгээнд зориулсан тусгай багаж төхөөрөмж, шугаман хурдасгуурыг ашиглан эгэл бөөмсийн тодорхой урсгалыг урьдчилан тэмдэглэсэн хэсэгт тусгана. Элемент хэсгүүдийн урсгалын нөлөөн дор түрэмгий хортой эсийн ДНХ бүтэц нь эргэлт буцалтгүй устдаг бөгөөд энэ нь цаашдын хуваагдахаас сэргийлдэг. Цацрагийн эмчилгээний зорилго, тухайн өвчтөний онцлогоос хамааруулан альфа цацраг; бета цацраг; гамма цацраг; рентген туяа; нейтрон цацраг; протоны цацраг; пи-мезоны цацраг зэргийг өргөн ашигладаг бөгөөд эмчилгээний бусад аргуудтай хослуулах нь элбэг. Цөмийн эгэл хэсгүүдийн урсгал буюу цацраг туяаны нөлөөгөөр хавдрын эсийн ДНХ бүтэц нь эвдэрч устдаг учир эсийн цаашдын өсөлт, хуваагдалт зогсоно. Хорт хавдрын эсүүд идэвхтэй, илүү хурдтай хуваагдаж байдаг учир цацраг туяаны иончлолд эрүүл эд, эсээс илүү өртөмтгий, иймээс хурдан мөхдөг. Хорт хавдрын эсийн ДНХ-ийн бүтэц нь цацрагийн эмчилгээний явцад түүний өсөлт, хуваагдалд саад учруулдаг усны цацраг идэвхжил, эсийн цитоплазмын өөрчлөлтийн улмаас хурдан эвдэрнэ.

**Зорилтот эмчилгээ:** Энэхүү эмчилгээний арга нь химийн эмчилгээтэй төстэй боловч зөвхөн тухайн хавдарт нөлөөлөх эсрэг биет, генүүд, уургуудын тусламжтайгаар хавдрын өсөлт, хуваагдал, тархалтыг зогсоодог. Эдгээр молекулт нэгдлүүд нь эсийн өсөх, хуваагдах дохиог хааж эсвэл бүүр ажиллагаагүй болгохоос гадна эрүүл эсүүдийг илүү удаан амьдрах нөхцөл боломжоор хангадаг. Харамсалтай нь энэхүү аргыг бүх төрлийн хавдрыг эмчлэхэд ашиглах боломжгүй байгаа юм. Уг эмчилгээний арга нь моноклонал

эсрэг бие болон жижиг молекулт нэгдлүүдийн тусламжтайгаар зарим төрлийн хөхний, уушгины хавдар зэргийг эмчлэх боломжтой байгаа юм. Өвчтөний биед оруулсан эсрэг биетүүд хавдрын эсийн гадна талд эсвэл эсийн дотор талд байрлаж эсийг үхүүлэх хорт бодис ялгаруулж устгадаг бол жижиг молекулт нэгдлүүд хавдрын эсийн өсөх, үржих процессыг хаадаг.

**Дархлааны эмчилгээ:** Дархлааны эмчилгээ нь өвчтөний өөрийн дархлалын системийн идэвхийг нэмэгдүүлж хавдрын эс болон халдварыг устгадаг эмчилгээ юм. Ингэхдээ халдвар болон хавдрын эсийг илрүүлдэг хяналтын цэгийг идэвхжүүлж хавдрын эсийг устгадаг Т- эсийн тусламжтайгаар ажиллагаагүй болгодог. 2018 онд АНУ-ын Ж.П.Аллисон (James P. Allison) болон Т.Хонжо ((Tasuku Honjo) нар “Дархлааны эсүүдийн саатлуурыг дарангуйлснаар хорт хавдар өвчнийг эмчлэх боломж” нээлтээр Нобелийн шагналыг Анагаах ухаан, физиологийн салбарт хүртсэн байна. (<https://www.nobelprize.org/prizes/medicine/2018/summary>)

**Фотодинамик эмчилгээ:** Энэ арга нь фотохимийн урвалын үед үүсдэг хүчилтөрөгчийг ашиглан хавдрын эсийг устгахад үндэслэдэг. Энэ урвалд оролцдог бүрэлдэхүүн хэсгүүд нь биеийн эд эсэд байдаг, гэрлийн үйлчлэлээр идэвхэждэг хүчилтөрөгч, түүнчлэн гэрлийн энергийг мэдрэх, дамжуулах чадвартай тусгай бодисууд–фотосенсибилизатор (photosensitizers) юм. Гэрлийн нөлөөгөөр хүчилтөрөгч идэвхтэй байдалд орж улмаар хавдрын эсүүдэд сөргөөр нөлөөлдөг. Гэрлийн эх үүсвэрт тодорхой долгионы урт бүхий лазерыг ашигладаг. Фотодинамик эмчилгээ 2-3 орчим долоо хоног үргэлжилдэг ба цацраг туяа, хими болон мэс заслын эмчилгээтэй хослуулж болдог ажээ.

**Генийн эмчилгээ:** Аливаа хорт хавдар үүсэх шалтгаан нь ДНХ дотор явагддаг мутацитай холбоотой гэсэн онол сүүлийн үед хөгжиж байгаа боловч генийн код хаана, яагаад эвдэгддэг вэ гэдэг талаар эрдэмтэд тун бага мэдээлэлтэй байна. Генийн код эвдэрснээр хорт хавдар үүсдэг гэсэн онолоор бол хорт хавдар гэдэг бол янз бүрийн эрхтнүүдэд үүсдэг нэг төрлийн өвчин бус харин нэг ерөнхий зүй тогтлоор явагддаг 200 төрлийн өвчнүүдийн ерөнхий нэр гэж үздэг. Хүний биеийн хаа нэг хэсэгт нэг эс нь мутацид оронгуут тухайн эс ямар ч хяналтгүйгээр маш хурдан хуваагдаж эхэлснээр хавдар үүсдэг байна. Судлаачид хэдэн мянган генийн мутацийг илрүүлсэн төдийгүй генийн кодыг эвдэгдэхэд хүргэдэг 80 орчим хүчин зүйлийг нэрлээд байна.

### 5.3. Гипертерм эмчилгээний зарчим

Энгийн эсүүд харьцангуй өндөр 46°C температурт амьдрах чадвартай байдаг. Өвчтөний хавдартай хэсгийн эс, хавдартай эрхтэнг 41-46°C градус хүртэл тусгай аргаар халааж эмчлэхийг халуун эмчилгээ буюу гипертерм эмчилгээ гэж нэрлэнэ. Халуун эмчилгээний явцад нано соронзон төмөр агуулсан бодисыг хавдартай тухайн хэсэгт тариурын тусламжтай оруулна. Дараа нь өвчтөнийг хувьсах соронзон оронд оруулахад (давтамж 500 кГц) бодис бүхий хэсэгт дулаан ялгарч температур 42.5 (Цельсийн градус) –аас дээш температуртай болоход хавдрын эсийн өсөлт буурч, эмчилгээ үр дүнтэй болно (Зураг 5.2).



Зураг 5.2. Халуун эмчилгээ хийх зарчим

Хавдрын эд, эс нь эрүүл эсийг бодвол метаболизм (бодисын солилцоо) өндөр, цусан хангамж их, хурдан өсөж үрждэг учир судас багатай эрүүл эдтэй харьцуулахад халууныг даах чадвар багатай байдаг.

## 5.4. Феррит нэгдлийг хаврын эмчилгээнд туршсан судалгаа

